



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,  
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026.05.06 № 01/349  
танай 2025.04.09-ны № 01/334 -Т

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.13 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаал "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын 3.10 дахь заалтын хүрээнд "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн OSH 2506/2521 дугаартай тайлан"-ийн зөвлөмжийн дагуу "Хөдөлмөрийн нөхцөл сайжруулсан ажлын тайлан"-г гарган хүргүүлж байна.

Хавсралт 76 хуудастай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

1526030345

Цаг уур, орчны шинжилгээний газрын  
2026 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн  
01/349 дугаар албан бичгийн хавсралт

## ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ САЙЖРУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон харьяа байгууллагуудын ажлын байран дахь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2025 оны 6 дугаар сарын 02-13-ны өдрүүдэд хийж “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан OSH 2506/2521” ирүүлсэн. Уг тайлангаар өгсөн ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

### 1. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ:

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хүрээнд бодлогын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог бүрдүүлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

2025 оны 08 дугаар сарын 01

“Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын зарим ажлын байранд хийлгэсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2025 оны 8 дугаар сард Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан баталж, харьяа байгууллагуудад хүргүүлсний дагуу төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сард БОУАӨЯ-нд хүргүүлсэн.

2025 оны 09 дүгээр сарын 24

Цаг уур, орчны шинжилгээний газрын “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ”-г Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран хийх ажлын хэсгийг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн А/202 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг үнэлгээг байгууллагын хувьд тохиолдож болох аюул, эмзэг байдал, чадавхын харилцан хамаарлаар 7 бүлгийн 27 үзүүлэлтийн оноогоор үнэлж, аюул эрсдэлийн түвшинг тодорхойлсон.

2025 оны 10 дугаар сарын 06

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг харьяа байгууллагуудад Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/214 дугаар тушаалаар томилсон.

2025 оны 11 дүгээр сарын 05

Цаг уур, орчны шинжилгээний газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр баталж, дээр дурдсан байгууллагын эрсдэлийг бууруулах 2025-2028 оны төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөгөөр байгууллагын дэд бүтцийн асуудлуудыг бүрэн шийдвэрлэсэн нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чухал алхам болсон.

2026 оны улсын болон орон нутгийн төсөвт дараах зардлуудыг тусгаж шийдвэрлэсэн. Үүнд:

- ЦУОШГ-ын барилга байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн хүчитгэл хийх-560,0 сая төгрөг,

- Төв байрны цахилгаан түгээх сүлжээ тасарсан үед ажиллах нөөц дизель генератор худалдан авахад-300 сая төгрөг,

- Цахилгаан хангамжийг шинэчлэх, интернэт холбооны зурвасыг өргөтгөж шинэчлэх,

- Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчдыг тусгай хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн байна.

- Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/252 дугаар тушаалаар жишиг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам, зааварчилгаа”-г баталж салбарын хэмжээнд харьяа байгууллагуудад мөрдүүлж эхэлсэн.

- Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/288 дугаар тушаалаар 2026 оныг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил” болгон зарлах тухай тушаал, нэгдсэн төлөвлөгөөг гаргаж баталсан. Уг төлөвлөгөө нь 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, заавар” боловсруулах ажлын хэсгийг томилж ажиллуулсан.

- Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Цаг уур, орчны шинжилгээний газрын хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станцын антен цамхгийн байр, төв байрны ашиглалтын нөхцөл, барилга байгууламжийн техникийн бүрэн бүтэн байдал, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагын хэрэгжилтэд үзлэг, шалгалт зохион байгуулах үүрэг бүхий дотоод Ажлын хэсгийг” томилон ажиллуулсан.

Уг ажлын хэсэг нь төлөвлөгөө гарган батлуулж, дээрх ажлын байруудад үзлэг, шалгалт хийж, дүгнэлт, саналыг гарган Цаг уур, орчны шинжилгээний газрын удирдах бүрэлдэхүүнд танилцуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сар бүр гарган Захиргааны хэлтсийн даргад танилцуулж байна.

- Цаг уур, орчны шинжилгээний газрын 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/43 дугаар тушаалаар “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, заавар батлах тухай” тушаал гаргаж салбарын хэмжээнд мөрдөж эхэлсэн.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт 1999 оноос хойш мөрдөгдөж ирсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг цаг үеийн хэрэгцээ шаардлага, технологи, аргазүйн шинэчлэлд нийцүүлэн боловсруулсан бөгөөд ажлын хэсэгт ЦУОШГ, харьяа байгууллагын болон 21 аймгийн төвийн дарга нар орж, чиглэл чиглэлийн дүрмүүд дээр ажилласан.

Шинэчилсэн дүрэм 13 бүлэгтэй бөгөөд Допплерийн радарын станц, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа, нислэгийн цаг уурын үйлчилгээ зэрэг өмнө тусгагдаагүй шинэ чиглэлүүд нэмсэн. Мөс, мөстөлтэй гол дээр ажиллах аюулгүй ажиллагааны журам болон цаг уурын автомат станцтай ажиллах зааврыг анх удаа тусгайлан оруулсан нь онцлог юм. Мэдээлэл, холбооны сүлжээний бүлгийг шинэ технологид нийцүүлэн шинэчлэхийн зэрэгцээ ослын үеийн анхны тусламжийн заавар, ажлын хамгаалах хувцасны стандартыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжрууллаа. Уг дүрмийн төслийг 2026 оны 2 дугаар

сарын 10–25-ны хооронд [www.weather.gov.mn](http://www.weather.gov.mn) веб сайтад байршуулж, санал авах ажлыг зохион байгуулж, 13 байгууллагаас ирүүлсэн саналыг хэлэлцэж, тусган ажилласан байна.

<https://namem.gov.mn/uploads/content/43.pdf> хаягаар орж дүрэм, заавартай танилцах боломжтойгоор нээлттэй байршуулсан.

2026 оны 6 дугаар сарын 10, 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил - 2026 нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагуудаар гаргаж БОУАӨЯ-нд хүргүүлэх бөгөөд Төсвийн шууд захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээтэй холбож хариуцлагыг нэмэгдүүлсэн.

**2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, дугаар OSH 2506/2521, Б.Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт:**

2.1 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2, 27.3, 27.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.19 дэх заалтын дагуу

- Хөдөлмөрийн эрүүл ахуйч ажиллуулах эсвэл ХАБЭА-н ажилтан хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр суурь сургалтад суусан байх.
- ХАБЭА-н ажилтан шаардлагатай тохиолдолд хэмжилт хийх чадвартай байх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах”

Харьяа 25 байгууллагад ХАБЭА-н ажилтныг томилж, чиг үүргийн ажилд оруулсан. Тайлангийн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын зарим ажлын байранд хийлгэсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Ус цаг уур, орчны шинжилгээний аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил-2026 төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг Харьяа байгууллагын ажилчдыг цахимаар, ажил олгогч нарыг болон ЦУОШГ-ын 50 ажилтныг танхимаар, нийт 8 цагийн сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулсан.

2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Хан-Уул дүүргийн Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” сургалтыг Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны ерөнхий инженер нийт 30 хүнийг хамруулан зохион байгуулсан.

Цаашид жил бүр нийт ажилтны сургалт, Ажил олгогчийн сургалтыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/130 дугаар тушаалын дагуу сургалтыг зохион байгуулж байхаар сургалтын төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр баталсан.

Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 25 байгууллага, агентлагийн нэгдсэн төсөв 2026 онд Эд хогшил, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 883,825.4 төгрөгөөр батлагдсан байсныг салбар дотроо зохицуулалт хийж 1,118,424.5 төгрөгөөр батлан 451,367.2 төгрөгөөр нэмэгдүүлэн, төсвийн хуваарьт 100 хувь хасагдсан “Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл”-ийн зардлыг тусгаж өгсөн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар хамтран ажиллах гэрээ байгуулан “Эрсдэлийн түвшин их ажлын байр” болох усны харуулын ажилтан 181 хүнд тус бүр 500,0 мянган төгрөгийн ажлын тусгай хувцас, хамгаалалтын хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж нийт 90,500,000 төгрөг олгосон байна.

**2.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 28.1.14, 26.2 дахь заалтуудын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж, шат дараатайгаар сайжруулалтыг хийх үр дүнг үнэлэх, төсөвт дараах зүйлсийг батлан,**

- Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах төсөв /ажилтнуудын ажлын байрыг сайжруулах, засварлах, ерөнхий агааржуулалт, ажилтнуудын түр амрах байр .../
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн сургалт зохион байгуулах төсөв
- Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн төсөв

Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилготой 2024-2026 онд шилжин хийгдэх 3 аймгийн УЦУОШТөвийн ажлын байр, цаг уурын 3 станцын барилгын ажлыг гүйцэтгэгч компаниуд үргэлжлүүлэн 50-90 хувийн гүйцэтгэлтэй байна. БОУАӨСайдын 2025 хөрөнгө оруулалтад батлагдсан 6,5 тэрбум төгрөгөөр цаг уурын 20 станцын ажлын болон түр амрах байр, 17 усны харуулын байрны зураг төсвийг эрчим хүч, дулаан хэмнэлттэй, инновац шингэсэн шинээр батлуулсан зураг, төсвөөр барихаар шийдвэрлэн, 9 багц болгон Төрийн худалдан авах ажиллагааны газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар хүргүүлсэн боловч 2,5 тэрбум төгрөгийн 4 багц ажил болох 9 цаг уурын станц, 10 харуулын байр барих ажлын гэрээ хийгдэж 2025 оны жилийн эцсээр 2 цаг уурын станц, 6 харуулын байр ашиглалтад орсон. 2026 онд үлдсэн байрууд бүрэн ашиглалтад орно. Их засварын ажилд Хөвсгөл, Сэлэнгэ, Баян-Өлгий аймгийн их засвар хийх компаниуд шалгарч ажлыг бүрэн гүйцэтгэсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв, станц, харуулын байр, дулаан хангамж, сантехникийн засвар хийхээр Сайдын 2025 оны А/127 дугаар тушаалаар 8 аймгийн 11 цаг уурын станцын барилган болон сантехникийн их засварын ажилд 800,0 сая төгрөг, Төв байрны засварт 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Хатгал тосгоны Нуур судлалын лабораторийн их засварын ажил 100 хувь, дуусан улсын комисс хүлээн авсан.

Цаг уур, орчны шинжилгээний газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг жил бүр БОУАӨСайдаар батлуулан 5 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, 2025 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө 92,3 хувиар дүгнэгдсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2025 онд танхимаар дотоодын 8 багц сургалт, гадаад сургалтад 103 хүн хамруулсан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулсан.

2025 оны 5 дугаар сард Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулахад өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор гүүглэ форм ашиглан цахимаар 5 багц судалгааг 1893 албан хаагчдаас 1372 албан хаагч буюу 72,5 хувийг хамруулан авсан бөгөөд Үүнд:

1. Судалгаанд хамрагдсан ерөнхий мэдээлэл
2. Албан хаагчдын ажлын байрны орчин, нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа
3. Цалин хөлс, урамшуулал, тэтгэмж, ээлжийн амралт
4. Эрүүл мэнд, гэр бүл
5. Санал

Дээрх судалгааны үр дүнг ашиглан Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологийн шинэчлэл-2026 төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2026 оны 43 дугаар тушаалаар "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, ажлын тусгай хувцас, хэрэгслийн загвар,

ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдах ажлын нэр, ашиглалтын хугацааг тус тус баталсан байна.

**2.3 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 28.1.6 дахь заалтын дагуу** ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчин үүсэхээс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн эрүүл ахуйн журам боловсруулан мөрдүүлэх;

- Эрүүл ахуйн ерөнхий шаардлагуудыг журамлаж хэрэгжүүлэх;
- Эрүүл ахуйн багаж хэрэгсэл ашиглах, үр дүнг боловсруулах;
- Гараар ачаа зөөх, өргөх эргономик, гараар ажил гүйцэтгэх үеийн эргономик /ачаа өргөх, зөөх, буулгах, байнгын суугаа ажил хийх үед түр амрах зэрэг/
- Ажлын хувцас хамгаалах хэрэгслийн журамд ажлын орчин нөхцөлд таарсан хувийн хамгаалах хэрэгслийг олгох,

Цаг уур, орчны шинжилгээний газраас Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг баталж, 2026 оны 3 дугаар сарын 09-ны өдрөөс мөрдүүлэн ажиллаж байна. Уг дүрэм зааварт эрүүл ахуйн ерөнхий шаардлага, эрүүл ахуйн багаж хэрэгсэл ашиглах, үр дүнг боловсруулах, ажлын хувцас хэрэгслээр хангах, ажлын орчин нөхцөлд таарсан хувийн хамгаалах хэрэгслийг олгох зэргийг журамлаж өгсөн.

Гараар ачаа зөөх, өргөх, эргономик, гараар ажил гүйцэтгэх үеийн болон байнгын суугаа ажил хийх үед түр амрах зэргийн агентлагийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/252 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам, зааварчилгааг батлах тухай" байна.

**2.4 Ажлын ачааллыг тэнцвэржүүлэн, ажилтай холбоотой ядралтаас сэргийлэх:**

- "Хөдөлмөрийн тухай" хуулийн 43.2.11 ажилтныг хуулиар тогтоосон заалтыг баримтлан ажлын цагт зохицуулалт хийж, уртын ээлжээр 14/14 хоногоор, өдөрт 12 цагаар ажиллуулах
- Илүү цагийн ажил гүйцэтгүүлэх тохиолдолд алжаал ядаргааг үнэлэх, ажилтны саналд үндэслэх;
- Илүү цагаар ажилласан тохиолдолд унтаж амрах хугацаа олгох;
- Ажилтны тоог нэмэх, илүү цагийн нэмэлт урамшуулал олгох.
- Амралтын цагаар дасгал хөдөлгөөн хийх тоног төхөөрөмжөөр тохижуулсан байраар хангах

Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээнд бүх харьяа газруудад "Хөдөлмөрийн тухай хууль"-ийг болон хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.11 дэх заалтыг мөрдөж ажилладаг.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Хяналт, дотоод аудитын хэлтсээс 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд агентлагийн албан хаагчдын 2025-2025 оны байдлаар илүү цагаар ажилласан алба хаагчдын илүү цагаар ажилласан нэмэгдлийг олгосон эсэх, илүү цагаар ажилласан шалтгааныг тодруулах зорилгоор 4 асуулт бүхий судалгааг хийсэн.

Дээрх төлөвлөгөөт бус дотоод аудитын шалгалтаар "Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т "шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно", 109.8-д "Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно" заалтыг хэрэгжүүлээгүй, ЦУОШГ-ын даргын тушаал шийдвэргүйгээр шөнийн ээлжийн 22 албан хаагчдад шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг тооцож олгохдоо албан тушаалын чиг үүрэгт тусгагдаагүй эрх мэдлээ хэтрүүлж дундаж цалин хөлсийг 0.3 хувиар тооцож шөнийн нэмэгдэл цалинг 2024 онд 17,062,689 төгрөг, 2025 онд 30,631,733 төгрөг дутуу олгосон байна" зөрчлийг илрүүлж, нөхөн олгох зөвлөмжийг

өгсөн бөгөөд зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан байна.

**2.5 "Эрүүл мэндийн тухай" 44.1.2 дахь заалтыг үндэслэн ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах**

- Эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн нийтлэг өвчлөлд ажлын байрнаас шалтгаалсан эсэхэд дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх байдлаар ажилтнуудад эрүүл мэндийн боловсрол олгох /мэргэжлийн байгууллагын сургалт, зурагт хуудас байрлуулах.../;
- Хөдөлмөрийн чадвар түр алдалтыг судалж, ажилчдын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийг тогтоож, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
- Ажилтнуудын дунд түгээмэл тохиолдож буй өвчнөөс урьдчилан сэргийлж өдрийн хоолны илчлэгийг зохимжтой байдлаар мөрдүүлэх, гэдэсний халдварт өвчин дамжуулахгүй тулд ариутгал цэвэрлэгээ сайтар хийх, аяга тавгийг тус тусад нь байлгах зэрэг арга хэмжээ авах
- Ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таниулах, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг сургалтын хөтөлбөрт тусгах
- Зонхилж буй өвчлөлийн шалтгааныг бууруулах сургалт зохион байгуулах (ажлын байрны зөв байрлал, хөдөлгөөн, стресс тайлах арга гэх мэт).

Цаг уур, орчны шинжилгээний газраас “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил-2026” хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.

<b>Зорилго 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандартын зохицуулалтыг салбарын онцлогт нийцүүлэн боловсронгуй болгох</b>						
33	Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг боловсруулж БОУАӨСайдаар батлуулан мөрдөнө. - Салбарын болон ХАБЭА-н дүрэм журмын эмхэтгэл бэлтгэх -Салбарын хэмжээнд сургалт зохион байгуулах, мэдлэг чадварын шалгалтыг авч хэвшүүлэх - Хэрэгжүүлсэн ажлын тайланг 12 сарын 05-ны дотор албан бичгээр эргэж мэдэгдэх	Улсын төсөв	Салбарын аюулгүй ажиллагааны заавар батлагдаж, мөрдөгдөх	-	Эмхэтгэл гарсан, сургалтууд зохион байгуулагдсан байна.	I-IV Улирал  УСГ, ТИХ, Харьяа байгууллагууд
34	ХАБЭА-ын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинэчилнэ. -Харьяа байгууллагуудад зөвлөмж өгч, нийтлэг жишиг журам батлах -Аюулгүй ажиллагааны зурагт болон видео контентыг хийж түгээх -Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, тэмдэглэгээний эхийг бэлтгэж орон нутаг, харьяа байгууллагуудад өгөх -Эх загварын дагуу тэмдэгжүүлэх	10.0	1.Журам-1 2. Контентын тоо 6-12 3. Эхийг бэлтгэсэн зааварчилгааны тэмдэглэгээ, 4. Тэмдэгжүүлсэн байдал		Төлөвлөгдсөн ажлууд хийгдсэн байна.	I-IV Улирал  Харьяа байгууллагууд, УМГ-ын Мэдээллийн студи
35	Салбар дахь эрсдэл ихтэй ажлын байрны ХАБЭА-ын жишиг заавар, зааварчилгааг боловруулж мөрдүүлнэ. -Суперкомпьютер -Кибер аюулгүй байдлын (Серверийн компьютерүүд болон бусад) журам боловсруулах -Гидробиологийн лаборатори -Цаг уурын автомат станц төхөөрөмжлөх, суурилуулах, ашиглалтын үеийн заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа	Улсын төсөв	Дүрэм, журам-6	0	Журам батлагдсан байна.	I-IV Улирал  УСГ, Харьяа байгууллагууд

	-Суурин болон зөөврийн радарын станцууд -Нөөц дизель генератор					
36	Харьяа байгууллагууд жил бүр техникийн ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үзлэгийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч, эрүүл мэндэд нь анхаардаг хэвшлийг бий болгоно. -Ажлын байран дахь анхан шатны, давтан зааварчилгааг стандарт шаардлагын дагуу ажилтанд тогтмол өгч хэвшүүлэх -Ажилтны стресс тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимтай болох хөдөлгөөнийг өрнүүлж ажиллах	Улсын төсөв	Эрүүл мэндийн үзлэг  Зааварчилгаа  Өрөө танхим	-	ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	I-IV Улирал  Харьяа байгууллагууд
37	Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ажлын байрны онцлогт тохируулан хуулиар хориглоогүй эх үүсвэр, хамтын ажиллагааны хүрээнд олгох	Улсын төсөв, ОНТ	Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл	-	ХАБЭА-ын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	I-IV Улирал  Харьяа байгууллагууд
38	Байгаль орчны шинжилгээний лабораториудын ажлын байрыг "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д оруулах, хөдөлмөрийн хэвийн бус нэмэгдэл олгох эсэх асуудлыг судлан шийдвэрлэнэ. (Дархан-Уул аймгийн жишгээр)	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалд нэмэлт оруулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх	-	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг тогтоосон байна.	I-IV Улирал  УАӨОШХ, УЦУОШТөвүүд
39	Цаг уурын салбарын болон Байгаль орчны шинжилгээний лабораторийн шинжээч, инженер, техникч нарт хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох асуудлыг судлан шийдвэрлэнэ.	Улсын төсөв	Засгийн газрын тогтоол гаргах	-	Засгийн газрын тогтоол батлагдсан байна	I-IV Улирал  УАӨОШХ, УСГ БОХЗТЛ
40	Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг 2026 оны 6 сарын 10, 12 дугаар сарын 05-нд гаргаж ЦУОШГ-ын ТИХ-т ирүүлнэ.	Улсын төсөв	Тайланг ирүүлсэн байх	-	Тайлан нэгтгэгдэж Газрын даргын зөвлөлд танилцуулагдсан байна.	I-IV Улирал  Агентлагын газар, хэлтэс, харьяа байгууллагууд

Харьяа байгууллага бүр ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц шинжилгээнд хамруулан ажилладаг, 2026 оны жилийн ажлын төлөвлөгөөнд батлагдсан ба тухайлбал тус агентлагийн харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нийт албан хаагчдыг 2024 онд "Сонгдо" эмнэлэгт, 2025 онд "Нура" төвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц шинжилгээнд хамруулах арга хэмжээнд нийт 62.2 сая төгрөг, цацрагийн эх үүсвэртэй харьцаж ажилдаг ажилтнуудыг жилд 1 удаа мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвд багц шинжилгээнд хамруулж 760,000.0 төгрөг зарцуулаад байна.



БАТЛАВ  
"БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ  
ЛАБОРАТОРИ" ЗАХИРАЛ  
Б. ЦАЦРАЛ



БАТЛАМ  
"СОУДСЭВНОРС ТӨВЕР" ХХК-ийн  
Гүйцэтгэгч захирал  
Б.НАЦРАЛ  
ММОНХУУЛ  
УБ СОНГОД ЭМНЭЛГИЙН БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ ТУХАЙ ГЭРЭЭ  
Гэрээ 2023...

2023 оны 12 дугаар сарын 08-ний өдөр Улаанбаатар хот

Мангос Улсын Иргэний хуулийн 189 дүгээр туйл 189.5 дэм хэсгийг уялралаг болголт.

Игч талдас Мангос Улсын хуулийн этгэмэ улсын бүртгэлийн № 9070001039 тоот гэрээлэгтэй №50593113 тоот регистрийн дугаартай "Байгаль орчин хэмжэл зүйн төв лаборатори" дэвдэнд "Газаруулга" гэдэг түүнийг өмөөрөж Хүний нөөцийн ажлааан дэвн тушаалтай Б.Өдөс

Нэсөө талдас Монгол Улсын хуулийн этгэмэ улсын бүртгэлийн № 5011289358 тоот гэрээлэгтэй "Соуд Сэвнорс Төвөр" ХХК-ийн УБ Сонгодо Эмнэлэг дэвдэнд "Эмнэлэг", тус бүрийг "Газ", хэмдэг нь "Газаруулга" гэдэг түүнийг өмөөрөж бизнес мөнгөөр дэвн тушаалтай, Д.Давасурин нар дараа нөөцлэйг хэлэлцэн төлөрөөлөж, харилцаа зохиоорсогөөр энэхүү гэрээг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хотод байгуулав.

Игч, Нийлэгч үндэслэл

1. Энэхүү Гэрээний гэдэг жорлод нь өмөөлөгч нь үйлчлүүлэгчийг хүсэлтээр түүний ажлааан дэвн тушаалтай хэвсгэлт 1-т шалтат орнод өмөөлөгч өмөөлөгч дэвдэнд "Шинжилгээ" гэдэг тус өмөөлөгч хийг ажлааан гүйцэтгэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохиоорсогөөр оршино.
2. Газаруулга нь дэвн хэлтэрт ажлааан эрх өгөж байх, харилцаа ашигтай байх гүйцэтгэлийн тэргэмэг баримтааан.
3. Энэхүү Гэрээнд гүйцэтгэгчтэй Газаруулга хооронд үүссэн бүхэл харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон Эрүүд мэдээний тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомоонд хамтаа дэвн зохиоорсогөөр оршино.
4. Энэхүү Гэрээ нь дарааг хэвсгэлээс бүрдэх ба хэвсгэлт нь гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй байна.  
Хэвсгэлт 1. Эмнэлгийн бичиг шинжилгээний гэрээ.  
Хэвсгэлт 2. Шинжилгээний хэвсгэлт ажлааан дэвн зохиоорсогөөр оршино.

**БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2024 оны 12 сарын 13-ний өдөр № Улаанбаатар хот

Энэхүү БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (дэвдэнд Гэрээ) гэдэгт хэв талдас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Таван Богд Гуримий төв байр хамт байрлах, регистрийн №501128 дугаартай "ТАВАН БОГД НУРА" ХХК, түүнийг төлөөлж Борлуулалтын мөнгөөр албан тушаалтай О.Ууганзориг (дэвдэнд Гүйцэтгэгч) гэдэг, Нөгөө талдас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Тангисийн өргөн чөлөө, 20-р хороо өөрийн байр хамт байрлах, №50593113 регистрийн дугаартай "БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ", түүнийг төлөөлж Хүний нөөцийн ажлаа мэрэжлэнтэн албан тушаалтай Б.Өдөс (дэвдэнд Үйлчлүүлэгч байгууллага) хамтад нь "Газаруулга" гэдэг нар Монгол Улсын Иргэний хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн доорх нөхцөлдүүдийг харилцаа төлөрөөлж байгуулав.

**НЭГ, НИЙЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгч байгууллагын ажлааанд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багц шинжилгээ, үйлчилгээг гэрээнд зассан нөхцөлөөр үзүүлэх. Үйлчлүүлэгч байгууллага нь ажилтны үндэслэлийг үнэн зөв гаргаж өгөж, нөгдсөн зохион байгуулагтаао хамгаах, хэмдэт тавих, гаргагчар тохирсон үнийг төлөж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багц шинжилгээ, үйлчилгээ (дэвдэнд Үйлчилгээ) гэдэг түүнтэй холбогдон үүсж харилцаа болон талуудын эрхлэх эрх, хүлээх үүрэг, харилцаа болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохиоорсогөөр энэхүү гэрээний зорилго оршино.

**Зураг. БОХЗТЛ-ийн ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн багц шинжилгээ үйлчилгээ үзүүлэх гэрээ**

Шинжилгээнд хамрагдсан албан хаагчдаас 1 албан хаагчид хавдрын шинж тэмдэг илэрч, эмчилгээ хийлгэж эхэлсэн. Эмчилгээний хугацаанд цалинтай чөлөө олгон ажиллаж байна. (Харьяа байгууллагуудын тайланг доор хавсаргав.)

ЦУОШГазрын ажилчдыг цайны болон амралтын цагаар дасгал хөдөлгөөн хийхэд зориулж спорт зааланд тус бүр нь 7,150,000 төгрөгийн үнэтэй гүйлтийн замыг байрлуулж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлсэн.

**3. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, дугаар OSH 2506/2521, А. Инженер, технологийн арга хэмжээний хэрэгжилт:**

1. Бүх ажлын байранд ерөнхий агааржуулалтын системийг төлөвлөж агааржуулалтыг сайжруулах, агаар чийгшүүлэх болон цэвэршүүлэх системийн нэмж агаарын чийглэгийн стандарт хэмжээнд хүргэх, хяналт, засвар үйлчилгээг тогтмол хийх
2. Гэрэлтүүлэг нь стандартын шаардлага хангахгүй байгаа ажлын байрууд нэмэлт гэрэлтүүлэг байрлуулж стандарт хэмжээнд хүргэх.

**1, 2 дугаар зөвлөмжийн хэрэгжилт:**

Цаг уур, орчны шинжилгээний төв байрны 3 дугаар давхрын машины заал, супер компьютерын өрөөний болон зоорийн давхрын цахилгааны нөөц тэжээлийн өрөөний агаар сэлгэлт, хөргөлтийн систем, галын аюулгүй байдлын систем 2025 оны 3 дугаар улиралд тус тус суурилагдсан. Баталгаат хугацааны туршид засвар үйлчилгээг суурилуулсан компани хариуцан ажиллаж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар "Цаг уур, орчны шинжилгээний газрын хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станцын антен цамхгийн байр, төв байрны ашиглалтын нөхцөл, барилга байгууламжийн техникийн бүрэн бүтэн байдал, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагын хэрэгжилтэд үзлэг, шалгалт зохион байгуулах үүрэг бүхий дотоод ажлын хэсгийг" томилон ажиллуулсан. Уг ажлын хэсэг нь төлөвлөгөө гарган батлуулж, дээрх ажлын байруудад үзлэг, шалгалт хийж, дүгнэлт, саналыг гарган ЦУОШГазрын удирдах бүрэлдэхүүнд танилцуулсан.

Ажлын хэсгийн дүгнэлтээр: Цамхгийн байрны ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, шийдвэрлэх асуудал:

1. Галын аюулгүй байдлыг дүгнэлтийг шинэчлэх;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг санамж, анхааруулга, тэмдэглээ хийх;
3. 1-9 давхрын угаалтуурын хоолойд аяган хоолойг суурилуулах. (бохир үнэртэхгүй болно);
4. 9, 10 дугаар давхарт болон дээвэр дээр (техникийн өрөөнд) нийт-3, В1 давхарт техникийн өрөөнүүдийг бүрэн харуулсан камер суурилуулах;
5. 7 давхарт разетикнаас гэрэл холбох ;
6. Заалны таазанд тогтоодог зориулалтын 12ш гэрэл авах;
7. Музейд хаалга болон бага хэмжээний барилгын засвар хийх ;
8. Дизель генератор ажиллуулах үед тусгай аюулгүй ажиллагааны заавар боловсруулж мөрдүүлэх;
9. В1 давхрын даралтын насос томруулах шаардлагатай. Насос нь жижиг тул халаад шатаад байдаг. Хүчин чадал сайтай насосоор сольсноор хуучин шинэ байрны хооронд байдаг дулааны шугам их хүйтрэх, насос унах үед хөлдөх эрсдэлгүй болно.
10. Агааржуулалтын хоолой дотор бохир, цэвэр усны шугам хамт байдаг тул хөлдсөн үед насос унаад 2 цаг болоход шугам хөлддөг. 3, 4 давхарт хөлдөөд цоолсон байгаа.
11. Узел болон техникийн өрөөнүүдэд цементээрээ байгаа, резинэн будаг, шалавч хийх.

#### **ТӨВ БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ТАЛААР:**

Дээрх барилга байгууламжид Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн-89, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар-15 орчим хүн ажилладаг.

Төв байрны А, Б блок барилгын хувьд 1-3 давхруудад хэсэгчилсэн засвар хийгдсэн байна. Хамгийн их эрсдэлтэй ажлын байранд төв байрны А блокийн баруун жигүүрийн нэгдүгээр давхар, А, Б блокийн зоорийн давхар бүхэлдээ байна. Энэ нь төв байранд ажиллаж байгаа нийт ажилтнуудад болон барилгын бүтээц, хийцэд нөлөөлөх цаашлаад хөдөлмөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэнэ гэж үзэж байна.

Иймээс ажлын байрны хамгийн их эрсдэл дагуулж байгаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, ахуйн байр буюу ажлын байрыг тодруулан авч үзвэл:

Төв байрны А блокийн баруун жигүүр нэгдүгээр давхрын байр ашиглалт

#### **Нэгдүгээр давхарт яаралтай хийгдэх ажлуудын санал:**

Тус давхарт ажиллаж байгаа мэдээллийн төрөлжсөн архивын ажилчид, ээлжийн болон үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах ажлын байран дахь эрсдэлийг бууруулах зорилгоор дараах ажлуудыг нэн яаралтай хийх шаардлагатай байна.

1. Газрын болон Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын ажилчдын ахуйн байрыг засах. Ялангуяа газрын ээлжийн ажилчдын амрах байранд шаардлага хангахгүй ор, кресло, ширээ, сандал зэргийг солих, хоол цай хийж идэх зориулалтын гал тогооны хэсэг плитка, ус буцалгагч, олон залгуураар хангах;

2. Тус өрөөний шал, цонхыг шинэчлэх, сайжруулах;

3. Нийтийн эзэмшлийн 00 өрөөний угаалтуурт аягатай хоолой суурилуулах, (бохир үнэртдэг) сэнс тавих;

4. Коридорын шалыг солих эсвэл сайн чанарын хулдаас дэвсэх;

5. Коридорт байгаа ашиглагдахгүй ширээнүүдийг шаардлагатай өрөө тасалгаанд шилжүүлэх, зайлуулах. Цэвэрлэгээ үйлчилгээ хийх боломжгүй байна;

6. Коридорын паарыг холбож засах. Дулаан алдаж байнгын цантай;

7. Доошоо зоорийн давхар болон аврах гарцыг цоожилсон байдалтай байсан. камер байрлуулах, аврах гарцыг чөлөөтэй байлгаж, зоорийн давхарт байрлаж буй техникийн өрөө рүү ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

8. Аваарын хаалгыг шинээр солих шаардлагатай. Уяагаар хүлсэн, дулаан их алддаг;

9. Үйлчлэгч болон төрийн үйлчилгээний ажилчдыг ажлын хувцас болон байгууллагын зарим эд зүйлийг угаах угаалгын өрөө, угаалгын машинтай болгох.

### **Зоорийн давхарт**

Мэдээллийн төрөлжсөн архиваар коридороор дамжиж зоорийн давхарлуу орно. Тэмдэг тэмдэглэгээ хэрэгтэй.

1. Баруун талын жижиг өрөө хогтой (хувцас);

2. Фитнесийн өрөө эвдэрхий хог, ашиглалт байхгүй (угаалтуур байсан. Усыг хаагаад бохирын шугамыг битүүлэх муухай үнэртэй);

3. Цахилгаан аваарын дизель хөдөлгүүр (засах) моторын өрөө;

4. Ахмадын өрөө ашиглалттай;

5. Узелийн өрөө (6 насос цэвэр ус-2, дүүргэлтийн-2, дулааны-2) Дүүргэлтийн насосын нэг нь ажиллахгүй байгаа;

6. Хүрээлэнгийн гидробиологийн лаб байсан 2 өрөө;

7. Хаалга цөмөрсөн дүүрэн хогтой өрөө, Зоорийн давхрын коридор битүү 5-6 том төмөр шкаф;

8. Хогтой (машины дугуй) өрөөнд нэмэлтээр паар тавина. Труба нь гаднаасаа цан цохиод хөлдөөд байгаа.

### **Яаралтай хийгдэх ажлууд:**

Энэ давхрыг бүрэн чөлөөлж техникийн аюулгүй ажиллагааг чанд мөрдөх.

1. Техникийн 2 өрөө байрлаж байгаа тул техникийн өрөөнд ажлаа хийх боломжийг олгох. Битүү төмөр шкаф байгаа тул гаргаж, коридорыг чөлөөлөх;

2. 5 өрөө хогоор дүүрэн. Гаргаж хаяж цэгцлэх. Дулааны болон цэвэр усны шугам хагарах аюултай тул засварлах боломжтой болгох;

3. Дизель нөөц станц байнгын ажиллагаатай тул тэсэрч дэлбэрэх аюултай. Тус техникийн өрөөг техникийн шаардлагын дагуу засах. Үүнд: Хаалга цонхыг солих, шал ханыг зориулалтын галд тэсвэртэй будгаар будах. Түлшний нөөцийг тусад нь хадгалах. (түлшний төмөр канистр) дизель станц, нөөц түлшийг хамт хадгалах хатуу хориотой. Хаалгыг найдвартай цоожоор цоожлох, аюулын санамж байрлуулах;

4. Галын зориулалтын хорыг коридор болон шатаар ордог хэсэгт байрлуулах;
5. Галын аюулгүй байдлыг булан байгуулах;
6. Фитнесийн өрөөг чөлөөлөх, дотор нь байгаа крантыг битүүлж хаах. Байнга бохир үнэртдэг;
7. Ахмадуудын өрөөг энэ давхраас гаргах. Энд ажиллах үед 2 ахмад (Шагай, Цээсодролцоо дарга орж байсан.) байсан. АЮУЛТАЙ;
8. Узелийн өрөөнд нэг насос шатсан яаралтай нэмэх. Нөөц насос авч бэлэн байдалд байлгах;
9. Машины дугуйтай дүүрэн хогтой өрөөнд паар тавих, цэвэрлэх, хаалга солих;
10. Нийт өрөө тасалгаанд цэвэрлэгээ хийж, хог хаягдлыг гаргах.

**Төв байрны зүүн буюу урд жигүүр зоорийн давхар:**

1. Сантехникч нарын өрөө (ээлжийн ажилчдын ахуйн байр, ажлын байр хамт) монометр харж байдаг.
2. Төрөлжсөн архивын өрөө
3. Төрөлжсөн архив
4. НПС батерей
5. Хан хэнтийн агуулах
6. Хүрээлэн агуулах
7. НПС-ийн UPS өрөө

**Яаралтай хийгдэх ажлууд:**

1. Сантехникч нарын өрөөг яаралтай засаж, доторх хогийг хаях. Ээлжийн ажилчдын ашиглах наад захын хэрэгцээг хангах (Ор, хувцас хадгалах шүүгээ, ус буцалгагч бусад),
2. Мэдээллийн төрөлжсөн архивыг ангилан цэгцлэх, цэвэрлэх, дулааны шугамуудад саадгүй хүрдэг болгох,
3. Галын аюулгүй байдлын булан болон галын хорыг үүдэн орох хэсэгт байрлуулах. Санамж байрлуулах,
4. Ашиглагч байгууллагуудад цэвэрлэгээний болон аюулгүй байдлыг хангаж ажиллахыг даалгах,
5. НПС-ийн UPS өрөөний аюулгүй байдлыг хангах.

Үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийн явцыг сар бүр Захиргааны хэлтсийн даргад танилцуулж байна. 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн явцын мэдээллээр хэрэгжилт дараах байдалтай байгаа ба 2026 оны жилийн эцсээр өрөөний агааржуулалт, гэрэлтүүлгийн асуудал бүрэн шийдэгдэнэ.

ҮЗЛЭГ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГАХ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

1. ЯАРАЛТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Шаардагдах зардал, эх үүсвэр	Хэрэгжүүлсэн үр дүн	Ажлын явц 2/13	Ажлын явц 3/24
1	Цаг уур, орчны шинжилгээний газрын байр ашиглалтын журмыг мөрдөж ажиллах	Нэн даруй	Бүх албан хаагчид	Шаардахгүй	Бүх албан хаагчид байр ашиглалтын журмыг мөрдөж ажиллаж байгаа	Өдөр бүр	Өдөр бүр
2	Байр ашиглалтын журмыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хан хэнтий тусгай хамгаалалттай газарт албан бичиг хүргүүлэх	Нэн даруй	Г.Болорсүх	Шаардахгүй	2026 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 04/23 тоот албан бичиг хүргүүлсэн.	2026 оны 2 дугаар сарын 09-ний өдөр	2026 оны 2 дугаар сарын 09-ний өдөр
3	Урьдчилан мэдээлэх газрын генераторт шатахууны нөөц бүрдүүлэх, хяналтын журнал хөтлөх	Нэн даруй	А.Ганзориг Б.Оюундарь	Шаардахгүй	Генератор ашиглах нөхцөл бүрдээгүй, ХАБ үүднээс шатахуунаар цэнэглээгүй		Шатахуун авсан тохиолдолд бүртгэлийн дэвтэр нээсэн.
4	Төв байрны коридорт байрласан том оврын төмөр шкафуудыг холдуулж зам талбайг чөлөөлөх	Нэн даруй	УЦУСМХ	Шаардахгүй	Коридорт байрласан том оврын төмөр шкафуудыг зөөвөрлөсөн	2 дугаар сард	
5	Генератор ажиллуулах аюулгүй ажиллагааны заавар боловсруулж мөрдүүлэх	Нэн даруй	Н.Энхмаа	Шаардахгүй	Генератор ажиллуулах үеийн аюулгүй ажиллагааны заавар, журам батлуулах Батлагдах арай болоогүй байгаа	-	Агентлагийн даргын 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/43 тушаалаар Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм зааврын 07 бүлгээр батлагдсан.

## 2. БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Шаардагд ах зардал, эх үүсвэр	Үр дүн	Ажлын явц 2/13	Ажлын явц 3/24
1	Давхар бүрийн ариун цэврийн ерөөний бохирын үнэрийн шалтгааныг арилгах (сифон, агааржуулалт, цэвэрлэгээ)	1-2 сар	В.Цогтсайхан	306,000	1-4 давхар хүртэл сольсон	2026 оны 2 дугаар сарын 10-13-ний хооронд	1-4 давхар хүртэл сольсон
2	Спорт заалны 2 душийн ерөөнд агааржуулалт суурилуулах	1-2 сар	В.Цогтсайхан				Илүү цагийн асуудал яригдаж байгаа учир халаалт зогсохоор хийхээр төлөвлөсөн.
3	Спорт заалны 1 ариун цэврийн ерөөний агааржуулалт суурилуулах	1-2 сар	В.Цогтсайхан				Илүү цагийн асуудал яригдаж байгаа учир халаалт зогсохоор хийхээр төлөвлөсөн.
4	Спорт заалны таазны гэрэлтүүлгийг засах, нэмэлт гэрэл суурилуулах	1 сар	А.Ганзориг				Гэрлүүдийг худалдан авсан. 4-5 дугаар сард хийнэ.
5	Зүүн жигүүрийн цахилгааны шит автоматуудыг солих	1 сар	А.Ганзориг				4 дүгээр сард УМГ-с зөвшөөрөл авч хэсэгчлэн солихоор төлөвлөж байна.
6	Төрөлжсөн архивын өрөөг цэгцэлж, хог хаягдлыг нүүлгэн шилжүүлэх	1-3 сар	Архив, Мэдээллийн сангийн хэлтэс		Өрөө байраар хангаж өгөхийг хүссэн		ББНШКомисс ажиллаж байна. Үүний дараа шилжүүлнэ.
7	Цонхны сийгэлтийг түр битүүлэх (резин жийргэвч, силикон)	1-2 сар	О.Оюунцэцэг Т.Төмөрсүх		Давхар бүхийг наасан	2026 оны 1 дүгээр сарын 5-29-ний хооронд	Давхар бүхийг наасан
8	Галын самбар хийх, Галын хор цэнэглэх	1-2 сар	А.Ганзориг		Самбар хийсэн, Галын хорийг 2025 онд		Самбар хийсэн, Галын хор цэнэглэх төсөв шийдэгдээгүй


					цэнэглэсэн. Хугацаа дуусах болоогүй.		
9	Хуучин байрны слесарийн өрөө болох В1 давхрын засвар	1-2 сар	О.Оюунцэцэг А.Ганзориг В.Цогтсайхан	825,000	Ажил явагдаж байгаа	3 дугаар сард	Бүрэн дууссан

### 3. ЖИЛИЙН ТУРШ ШАТ ДАРААТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Шаардагдах зардал, эх үүсвэр	Үр дүн		
1	Аврах гарцын 2 хаалгыг стандартын бат бөх хаалгаар солих	2026	ӨХБЗөвлөл		Санхүүжилт тодорхойгүй		Засварын ажил дуусахаар шийдвэрлэх
2	В1 давхрын музейн өрөөний үлдэгдэл засварыг бүрэн дуусгах	Дулаарах үед	О.Оюунцэцэг Х.Туулцэцэг		Гэрээ хийгдсэн, ажил хийгдэж байна		Гэрээ хийсэн хүмүүс ажлынхаа завсраар хийж байгаа. Дулааны улирал эхлэхээс өмнө байсан дуусгахаар тохиролцсон.
3	Дээврийн усны хаялга хийлгэх	2026	О.Оюунцэцэг	5,000,000	Ажил бүрэн хийгдэж дууссан.	2 дугаар сард	Ажил бүрэн хийгдэж дууссан.
4	В1 давхрын даралтын насосыг хүчин чадал сайтайгаар солих	2026	ӨХБЗөвлөл	1,500,000	Санхүүжилт тодорхойгүй		Санхүүжилт тодорхойгүй
5	Узел, техникийн өрөөнүүдэд резинэн будаг, шалны хамгаалалт хийх	2026	Н.Энхмаа				Санхүүжилт тодорхойгүй
6	200 кВА дизель нөөц цахилгаан станц шинээр суурилуулах	2026 он	Улсын төсвийн Хөрөнгө оруулалт		Улсын төсвөөр		Төрийн худалдан авах ажиллагааны газар 4 дүгээр сарын 8-ний өдөр тендер зарлагдана.

**3 дугаар зөвлөмжийн хэрэгжилт:** Байгаль орчны лабораторийн татах шүүгээний хэсгийн агааржуулалтыг шинэчлэн засварлах, хяналт хийх, засвар үйлчилгээг тогтмол хийх.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн агаарын шинжилгээний лабораторийн татах шүүгээний сорох шугамыг шинэчлэн засварлаж хэвийн ажиллагааг хангасан. /Зураг 2./



Зураг 2. Агаарын шинжилгээний лабораторид нэмэлт сорох шугам суурилуулсан байдал

**4 дүгээр зөвлөмжийн хэрэгжилт:** Гидробиологийн лабораторийг лабораторийн зориулалтын байр, өрөө тасалгаа, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах

УЦУОСМХүрээлэнгийн Гидробиологийн лабораторийг зоорийн давхарт байрлаж байсныг хөдөлмөрийн орчин нөхцөлийг сайжруулан төв байрны 3 давхарт нүүлгэн шилжүүлсэн. Төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж байгаатай холбогдуулан тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж чадаагүй.

**5 дугаар зөвлөмжийн хэрэгжилт:** Байгаль орчны лабораторийн химийн бодисын агуулахыг химийн бодис хадгалах агуулахын стандарт шаардлагын дагуу дахин төлөвлөх

ЦУОШГазрын харьяа тус лаборатори нь их хэмжээний химийн бодис хадгалах агуулах өрөөний шаардлагагүй бөгөөд хамгийн ихдээ 80 төрлийн, 0.01-2.5кг хэмжээтэй химийн бодис ашигладаг тул хүчил шүлт, галд тэсвэртэй цахилгааны аюулгүй байдлыг бүрэн хангасан тусгай зориулалтын химийн бодис хадгалах шүүгээг тохиромжтой гэж үзэж, 2025 оны байгууллагын давсан орлогоор уг шүүгээг худалдан авахаар “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулсан, 4 дүгээр сард багтаан худалдан авч ашиглана.

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ  
ЛАБОРАТОРИЙН ЗАХИРАЛ  
Б. ЦАЦРАЛ



ЛАБОРАТОРИЙН БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2026 оны 03-р сарын 25-ны өдөр

№26-13/15

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох РД:5609461 дугаартай "МИТГЭЙТ" ХХК (шаашда "Худалдагч" гэх)-ийг худалдааны менежер Р. Амарбаясгалан нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох РД:5059313 дугаартай "БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" (шаашда "Худалдан авагч" гэх)-ийг төлөөлж Байгаль орны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа нар (хамтад нь "Тэргүү" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дугаар зүйл, үүргийн нийтлэг зохицуулалтыг тус тус үндэслэл болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээгэр Хавсралт 1-т заасан бараа бүтээгдэхүүн /шаашда "Бараа" гэх/-ийг хувиарийн агуу худалдаа, худалдан авахтай холбоотой талуудын хооронд түсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээ нь хавсралтад байх бөгөөд хавсралт нь гэрээний сонцгой хэсэг байна.
- 1.3 Худалдан авагч нь Худалдагчид барааны үнийг бүрэн төлж барагдуулаачаар түүнд амгачах эрх шийжнэ.

#### ХОЁР. БАРАА НИЙДҮҮГЭХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

1. Сум дундын ойн ангийг ажил үүргээ гүйцэтгэх тээврийн хэрэгслээр хангах
2. Байгаль хамгаалагч нарын ажлын байранд харилцаа холбоо, харуул хамгаалалтын тоног төхөөрөмжөөр хангах
3. Байгаль хамгаалагч нарт гал түймэрт хэрэглэдэг тоног төхөөрөмжөөр хангах
4. Байгаль хамгаалагч нарт ажлын байр луу явах болон ирэх тээврийн хэрэгслээр хангах
5. Байгалийн нөөцийн бодлого хэрэгжилтийн газрын мэргэжилтнүүдийг эргономикийн шаардлага хангасан сандлаар хангах, ажлын байрны мөөгөнцрийг арилгах

Дээрх зөвлөмжүүд нь манай байгууллагад хамааралгүй.

#### 11 дүгээр зөвлөмжийн хэрэгжилт: Мөнгөнморьт сумын цаг уурын газрыг тоног төхөөрөмжийг автоматжуулах

БОУАӨСайдын багцаас цаг уурын 10 автомат станцыг худалдан авахад шаардлагатай 1.0 тэрбум төгрөгийн шийдвэрлүүлж, техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас 02 дугаар сарын 17-ны өдөр тендерийг зарлан, 04 дүгээр сарын 25-ний өдөр нээлтийг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан боловч Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 05 дугаар сарын 31-ны дотор худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаагүй тул холбогдох зардлыг төсвийн хэмнэлтэд тооцож, хураагдсан.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын цаг уурын станцын тоног төхөөрөмжийг шинэ автомат станцаар хангаж чадаагүй ч хуучин Үдлэг станцын цаг уурын автомат станцыг шилжүүлэн суурилуулж хэмжилтийг хийж байна. Цаг уурын автомат станц нь тодорхой зарим нэг хэмжилтүүдийг хийж гүйцэтгэдэг боловч хөтөлбөрт бүх хэмжилт, судалгааг хийх боломжгүй бөгөөд улсын хэмжээнд автоматжуулах боломжгүй арга зүй, үйлдвэрлэлийн технологи, ажлын онцлогоос хамаарсан эрсдэлийн шинж чанар буурахгүй байна.

#### 12 дугаар зөвлөмжийн хэрэгжилт: Усны харуулын ажлын байрны амь насны эрсдэлийг арилгах зориулалтаар багаж тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулах

Ус судлалын 152 харуулаас 17 харуулд автомат багажийг нийслэл, 9 аймгийн 17 байршилд суурилуулах хуваарийг 2025 онд баталж, суурилуулах шаардлагатай төсвийг ОНТХөрөнгөөр санхүүжүүлэхээр Засаг дарга нарт 01/527 дугаартай албан бичгийг

Хавсралт 1. Бариагч нар, түүх хэмжээ

№	Сайт/ажил, үйлдвэр/материалын нэр	Төрөл/төр	М/н	Тоо	Нэгж үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	ЭХРС 7005 монгол улсын орны идэвхтэй 15 кг бүрэл 18 төрөл орны идэвхтэй төрөл сонгоо	Ид бүрэл	1	4 500 000	4 500 000
2	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	ЭХРС 7005 монгол улсын орны идэвхтэй 15 кг бүрэл 18 төрөл орны идэвхтэй төрөл сонгоо	Ид	1	2 250 000	2 250 000
3	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	ЭХРС 7005 монгол улсын орны идэвхтэй 15 кг бүрэл 18 төрөл орны идэвхтэй төрөл сонгоо	Ид	1	4 500 000	4 500 000
4	Хувилг тусгайг шилжүүл (D100mm) (0.5-0.8)	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	Ид	3	500 000	1 500 000
5	Хувилг тусгайг шилжүүл (D100mm) (0.5-0.8)	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	Ид	3	200 000	600 000
6	Хувилг тусгайг шилжүүл (D100mm) (0.5-0.8)	Монгол улсын орны идэвхтэй төрөл сонгоо бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) 15кг бүрэл (18 төрөл) (D100mm) (11 Номт)	Ид	1	6 000 000	6 000 000

хүргүүлсэн. Суурилуулалтын хүрээнд 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд ЦУОШГ-аас баталсан хөтөлбөрийн дагуу нийлүүлэгч компанитай хамтран RQ-30 автомат багажийн танилцуулга, Сэлбэ-Дамбадаржаа харуулыг автомат багажаар тоноглон суурилуулах үйл явцыг аймаг, нийслэлийн усны инженерүүд болон Гадаргын усны судалгааны хэлтсийн инженерүүдэд багаж ашиглалт, суурилуулахад анхаарах зөвлөмжийг өгсөн. Улаанбаатар хотын Туул, Сэлбэ, Завхан, Хөвсгөл, Баянхонгор аймгуудын Бүгсий, Түйн, Богд голуудад 5 автомат багажийн хэмжилтийн мэдээг мэдээллийн нэгдсэн системд дамжуулж, ажиглагчийн хэмжилттэй харьцуулан, тохируулгыг хийж ажилласан. Энэхүү төхөөрөмжийг суурилуулсны үр дүнд голын усны түвшин болон урсцыг 5 минут тутамд хэмжих мөн үерийн эрсдэлийг шуурхай тооцоолох боломжтой болсон. Тус 17 автомат багажийг урт хугацаанд ашиглах боломжийг судалсны дүнд өвлийн улиралд хурааж 2026 оны 4 дүгээр сард дахин суурилж хэмжилтийг үргэлжлүүлэн хийнэ.

Ус судлалын автомат багаж нь тодорхой зарим нэг хэмжилтүүдийг хийж гүйцэтгэдэг боловч хөтөлбөрт бүх хэмжилт, судалгааг хийх боломжгүй бөгөөд улсын хэмжээнд автоматжуулах боломжгүй арга зүй, үйлдвэрлэлийн технологи, ажлын онцлогоос хамаарсан эрсдэлийн шинж чанар буурахгүй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Н.ЭНХМАА

## **ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

### **БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори /БОХЗТЛ/ 1972 онд байгуулагдсан бөгөөд ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжлийн нэгдмэл байдлыг ханган, улсын хэмжээнд агаар, ус, хөрсний чанар болон цацраг идэвхжилийн түвшний орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг тасралтгүй шинжлэн судалж, агаар, орчны бохирдлын төлөв байдлын талаарх мэдээллээр төрийн байгууллага, нийгмийн хэрэгцээг шуурхай хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн төрийн үйлчилгээний байгууллага юм.

2025 оны байдлаар байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээ нь агаарын чанарыг хянах 48 харуул, гадаргын усны 193 харуул, хаягдал бохир усны 25 цэг, хүчиллэг тунадасны олон улсын сүлжээний 2 харуул, цацрагийн түвшний хэмжилтийн 35 цэг, хөрсний бохирдлын 500 гаруй цэг, цөлжилтийн ажиглалтын 1500 цэгээс тогтож байгаа бөгөөд Байгаль орчны шинжилгээний төв лаборатори нь энэхүү улсын сүлжээг мэргэжил арга зүйгээр хангаж, тогтоосон хөтөлбөрийн дагуу шинжилгээ судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Тус лаборатори нь өөрийн зориулалтын барилгагүй бөгөөд анх 1972 онд цаг уурын хэмжих хэрэгсэлд засвар үйлчилгээ, баталгаажуулалт хийх зориулалтаар баригдсан нэг давхар тоосгон барилгын суурийг хоёр давхар болгон аж ахуйн аргаар зүйж өргөтгөж барьсан барилгад одоо байрлаж байна. Уг барилга нь газар хөдлөлийг тэсвэрлэх боломжгүй, баригдсан цагаасаа хойш засвар хийлгүй явсаар 2008 онд улсын төсвийн хөрөнгөөр их засвар хийгдсэн, хэрэглээний халуун усгүй, хаягдал бохир усаа зайлуулах төвлөрсөн шугамд холбогдоогүй зөөврөөр хаягдал усаа зайлуулдаг.

Лабораторийн зориулалтаар ашиглаж байгаа өрөөнүүд нарийн хэмжлийн багаж суурилуулах зай талбай хүрэлцэхгүй жижиг, багажид тохиргоо, үйлчилгээ хийдэг баллонтой стандарт хий болон даралттай хийнүүдийг нэг дор байрлуулж байгаа нь ажиллуулах явцад аюул осол гарах эрсдэлтэйгээс гадна маш цэвэр ангиллын стандарт хийнүүд, урвалж бодисууд өөр хоорондоо урвалд орж бохирдох эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. 90 гаруй нэр төрлийн химийн аюултай болон хортой бодис хадгалах, урвалж уусмал, аналитик жин, химийн шинжилгээний шил сав угаах, хадгалах зориулалтын өрөө байхгүйгээс тэдгээрийг нарийн багажийн хажууд лабораторийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй газар байрлуулж байна.

Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн 2015 онд хийсэн Байгаль орчны хяналт шинжилгээний төв лабораторийн ажлын байранд хийсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр тус лабораторийн ажиллагсад хөдөлмөрийн хортой (хүнд) нөхцөлийн 2 болон 3 дугаар зэрэгт хамаарах орчин нөхцөлд ажиллаж байгааг тогтоосон.

Хүснэгт 1-д БОХЗТЛ-ийн ажлын байранд хийж гүйцэтгэдэг шинжилгээний тухай мэдээллийг харуулав.

## Хүснэгт 1. БОХЗТЛ-ийн ажлын байранд хийж гүйцэтгэдэг шинжилгээ


Ажлын байрны нэр	Нөхцөл
Усны чанарын хяналт шинжилгээний лаборатори	70 гаруй нэр төрлийн химийн бодис, урвалж ашиглаж гадаргын болон хаягдал усны сорьцод усны орчин (pH), цахилгаан дамжуулах чанар (ЕС), ууссан хүчилтөрөгч (O <sub>2</sub> ), биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ <sub>5</sub> ), химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ), жинлэгдэх бодис, перманганатын исэлдэх чанар (ПИЧ), аммони (NH <sub>4</sub> ), нитрит (NO <sub>2</sub> ), нитрат (NO <sub>3</sub> ), фосфат (PO <sub>4</sub> ), фторид (F), төмөр (Fe), цахиур (Si), гол ионууд болох усны хатуулаг, кальци (Ca), магни (Mg), сульфат (SO <sub>4</sub> ), хлорид (Cl) зэрэг 23 үзүүлэлтийг тодорхойлж байна.
Агаарын чанарын хяналт шинжилгээний лаборатори	19 нэр төрлийн химийн бодис, урвалж ашиглаж лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэдэг.
Хөрсний чанарын хяналт шинжилгээний лаборатори	20 нэр төрлийн химийн бодис, урвалж ашиглаж хөрсний чанарын хяналтын 409 цэгээс сорьц авч 13 үзүүлэлт буюу хүнд металл, нефтийн бүтээгдэхүүн агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлж байна. Цацрагийн эх үүсвэр бүхий багаж ашиглаж хөрсөн дэх хүнд металлын шинжилгээ хийж гүйцэтгэдэг.
Цацрагийн хяналт шинжилгээний лаборатори	Гадаад орчны цацрагийн түвшний ажиглалтыг орон нутгийн 36 харуул дээр өдөр бүр 8, 14 цагт хэмжиж байна. Монгол орны хэмжээнд жил бүр агаарын чанарын хяналтын 25 цэгээс 10 хоног бүр агаарын уналын тунадас, тоосонцрын 900 сорьц авч нийлбэр бета идэвхийн хэмжилт хийж байна. Цацрагийн эх үүсвэр ашиглаж шинжилгээ хийж гүйцэтгэдэг.
Агаарын даралтын лаборатори	Мөнгөн уст барометрийн гадаад үзлэг, шалгалт, баталгаажуулалт хийгддэг байсан.
Чийг, температурын лаборатори	Мөнгөн уст термометрийн гадаад үзлэг, шалгалт, баталгаажуулалт хийгддэг байсан.
Инженер, техникийн ажилтнуудын өрөө	Лабораторийн зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаа тул химийн бодисын шууд болон дам нөлөө их байдаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2025 онд хийсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр:

- Бүх ажлын байрны талбай нэг хүнд ноогдох 6 м<sup>2</sup> буюу стандарт шаардлагыг хангахгүй;
- Байгаль орчны лабораторийн бүх шинжээч нар, хүний нөөц, химийн бодисын бүртгэл хариуцсан мэргэжилтэн нарын ажлын байранд агаарын харьцангуй чийг хангалтгүй, гэрэлтүүлэг стандарт хэмжээнд хүрэхгүй;
- Ерөнхий агааржуулалтын систем байхгүй, лабораторийн татах шүүгээний хэсгийн татах агааржуулалт стандартын шаардлага хангахгүй;
- Химийн бодисын хадгалах байр стандартын шаардлага хангахгүй байгаа зэрэг нөхцөл үнэлэгдсэн.

Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

БОХЗТЛ-ийн захирлын 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/05 дугаар тушаалаар байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. /Зураг 1./

  
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2026 оны 02 сарын 16 өдөр      Дугаар А/05      Улаанбаатар хот


Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн  
зөвлөл байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б.Цацрал	Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал
Гишүүд:	Т.Түдээдагва	Усны урсгалын хурд, шугаман хэмжлийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч
	Б.Өөдөс	Хүний нөөц химийн бодисын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн
	А.Цолмонбаяр	Хаягдал усны хяналт шинжилгээ хариуцсан шинжээч
Нарийн бичгийн дарга:	Б.Даваасүрэн	Хөрсний чанарын хяналт шинжилгээ хариуцсан ахлах шинжээч

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, батлуулахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Даваасүрэнд тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд нягтлан бодогч Ч.Цэцэгдэлгэр нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ  Б.ЦАЦРАЛ



a/tushaal-2026-05

Зураг 1. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл байгуулах тухай тушаал

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн агаарын шинжилгээний лабораторийн татах шүүгээний сорох шугамыг шинэчлэн засварлаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. /Зураг 2./



Зураг 2. Агаарын шинжилгээний лабораторид нэмэлт сорох шугам суурилуулсан байдал

Өдөр тутмын шинжилгээний ажилд шаардлагатай хамгаалах хэрэгслийг (маск, хошуувч, резинэн бээлий, даавуу бээлий) худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлүүлж 2024 онд хувийн хамгаалах хэрэгсэл авахад 6.2 сая төгрөг, нормын хувцаст 10.0 сая төгрөг, 2025 онд хувийн хамгаалах хэрэгсэлд 4.6 сая төгрөг, нормын хувцаст 21.5 сая төгрөг зарцуулж сар бүр, ажлын хувцас, цагаан халад, ажлын тавчик зэргийг улирал болон жилээр нормын дагуу олгож байна. 2026 онд хувийн хамгаалах хэрэгсэлд 11.6 сая төгрөг, нормын хувцаст 3.4 сая төгрөг төсөвлөн үйл ажиллагаа явуулж байна.

Шингэн бодис асгарах үед авах арга хэмжээний иж бүрдэл, химийн бодис алдагдсан үед өмсөх тусгай зориулалтын иж бүрдлийг бэлтгэн шаардлагатай үед хэрэглэж байна.

Галын иж бүрдлийг албан контор дотор болон байгууллагын хашаанд байрлуулж, галын аюулгүй байдлыг жил бүр шалгуулж, дүгнэлтийг шинэчлэн авсан.



Зураг 3. Химийн бодис алдагдсан үед өмсөх тусгай зориулалтын иж бүрдэл



Зураг 4. Шингэн бодис асгарах үед авах арга хэмжээний иж бүрдэл

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нийт албан хаагчдыг 2024 онд “Сонгдо” эмнэлэгт, 2025 онд “Нура” төвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц шинжилгээнд хамруулах арга хэмжээнд нийт 62.2 сая төгрөг, цацрагийн эх үүсвэртэй харьцаж ажилдаг ажилтнуудыг жилд 1 удаа мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвд багц шинжилгээнд хамруулж 760,000.0 төгрөг зарцуулаад байна.



**БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2024 оны 12 сарын 13-ний өдөр № Улаанбаатар хот

Энэхүү **БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх) нэг талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Таван Богд Группийн төв байр хаягт байрлах, регистрийн 6481221 дугаартай "ТАВАН БОГД НУРА" ХХК, түүнийг төлөөлж Борлуулалтын менежер албан тушаалтай О.Ууганжаргал (цаашид "Гүйцэтгэгч" гэх), Нөгөө талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Тэнгисийн өргөн чөлөө, 20-р хороо өөрийн байр хаягт байрлах, 5059313 регистрийн дугаартай "БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ", түүнийг төлөөлж Хүний нөөцийн эрхлэх мэргэжилтэн албан тушаалтай Б.Өөлс (цаашид "Үйлчлүүлэгч Байгууллага", хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн доорх нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгч байгууллагын ажилтанд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багц шинжилгээ, үйлчилгээг гэрээнд заасан нөхцөлөөр үзүүлэх, Үйлчлүүлэгч байгууллага нь ажилтны мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх, нэгдсэн зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, гэрээгээр тохирсон үнийг төлөх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багц шинжилгээ, үйлчилгээ (цаашид "Үйлчилгээ" гэх) түүнтэй холбогдон үүсэх харилцаа болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

2023 оны 12 дугаар сары 08-ний өдөр Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйл 189.5 дэх хэсгийг удирдлага болгон,

Нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд улсын бүртгэлийн № 9070001039 тоот гэрчилгээтэй, №5059313 тоот регистрийн дугаартай "Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори" /цаашид "Үйлчлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Хүний нөөцийн ажилтан албан тушаалтай Б.Өөлс

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд улсын бүртгэлийн № 9011289058 тоот гэрчилгээтэй "Соул Сэниорс Төвөр" ХХК-ийн УБ Сонгдо Эмнэлэг /цаашид "Эмнэлэг", тус бүрийг "Тав" хамтад нь "Талууд" гэх/, түүнийг төлөөлж Бизнес менежер албан тушаалтай, Д.Даваасүрэн нар дараах нөхцлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зовшроосноор энэхүү гэрээг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хотод байгуулав.

**Нэг, Нийтлэг Үндэслэл**

- 1.1 Энэхүү Гэрээний гол зорилго нь эмнэлэг нь үйлчлүүлэгчийн хүсэлтээр түүний ажилтанд энэхүү гэрээний хавсралт 1-т заасан ерөнхий оноллогооны шинжилгээ /цаашид "Шинжилгээ" гэх/ тус эмнэлэгт хийх ажлыг гүйцэтгэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд аль аль нь хамтарч ажиллах, эрх тэгш байх, харилцан ашигтай байх туншлэлийн зарчмыг баримтална.
- 1.3 Энэхүү Гэрээнд тусгагддаггүй Талуудын хооронд үүссэн бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон Эрүүд мэдлийн тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохируулна.
- 1.4 Энэхүү Гэрээ нь дараах хавсралтаас бүрдэх ба хавсралт нь гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй байна.  
Хавсралт 1: Эмнэлгийн багц шинжилгээний төрөл,  
Хавсралт 2: Шинжилгээнд хамрагдах ажилтнуудын төрөийн жагсаалт;

Зураг 5. БОХЗТЛ-ийн ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн багц шинжилгээ үйлчилгээ үзүүлэх гэрээ

Шинжилгээнд хамрагдсан албан хаагчдаас 1 албан хаагчид хавдрын шинж тэмдэг илэрч, эмчилгээ хийлгэж эхэлсэн. Эмчилгээний хугацаанд цалинтай чөлөө олгон ажиллаж байна.

Байгууллагын 2025 оны төсвийн жилийн үйл ажиллагааны давсан орлогоос хүчилд тэсвэртэй диспенсер, диспенсерийн шилэн сав, хүчил шүлт, галд тэсвэртэй, химийн бодис хадгалах зориулалтын шүүгээ, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, химийн бодис алдагдсан үед өмсөх тусгай зориулалтын иж бүрдэл, батарей хадгалах зориулалтын сав авахад зориулж нийт 15,395,000.0 төгрөг, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 39,990,000.0 төгрөгийг төсөвлөн ажиллаж байна.

---oOo---

## ХОВД АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Ховд аймгийн УЦУОШТөвийн харьяа 16 суманд цаг уурын 9 өртөө 7 цаг уурын харуул, ус судлалын 10 харуултай нийт 87 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг. Ус цаг уурын шинжилгээний 9 өртөө нь тасралтгүй 24 цагийн үйл ажиллагааг өөрийн байранд явуулдаг, Алтай сумын цаг уур, ус судлалын харуулууд ажиглалтын талбайн хажуудаа өөрийн гэсэн байртай үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланд өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаа. Үүнд:

1. Ус цаг уурын салбарын тасралтгүй, шуурхай ажиллагааны хүрээнд ээлжийн ажилтай 59 хүн ажилладаг бөгөөд 2025 онд шөнийн нэмэгдэлд 102 сая төгрөг, илүү цагийн нэмэгдэлд 78,5 төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 281,7 сая төгрөг зарцуулсан байна.

2. Ажилчдын ажиллах таатай орчин нөхцөл бүрдүүлэх хүрээнд: Энэ онд салбар нэгжүүд нийт 52,500,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгаасаа шийдүүлж ажилчдын ажиллах тав тухтай орчин нөхцөлөө сайжруулж ажиллажээ. Үүнд: Зэрэг цаг уурын өртөөний барилгын дотоод тохижилтод шаардлагатай 5 сая төгрөгийн санхүүг орон нутгийн хөгжлийн сангаас шийдүүлсэн. Үүнд: 4 том цонх шиллэх, 2 өрөөний хулдаас 40 метр, 4 ширхэг сандал, ор, өртөөний танилцуулгын шүүгээ тавиур, өрөөнүүдийн гэрэл, хөшиг, үзүүлэн самбар зэрэг бараа материалыг авч өрөө байраа тохижуулан өртөөний ажилчдын ажиллах тав тухтай орчин бүрдүүллээ.



Зураг 1. Цаг уурын Зэрэг өртөөний өрөөний тохижилт хийсэн нь

3. Дунд-ус цаг уурын өртөөний барилгын гадна доторх засварын ажлыг 10 сая төгрөгийн санхүүжилтийг сумын ОНХС-аас шийдүүлж тус өртөөний өрөөнүүдийн /4 өрөө/ тааз дулаалах, хана, таазыг тусгай зориулалтын хавтангаар доторлох, гадна хаалга солих, нам даралтын зуух тавьж доторх халаалтыг шийдэх зэрэг ажлуудыг хийж, ажилчдын ажиллах тав тухай орчин нөхцөл сайжирсан.




Зураг 2. Дунд ус өртөөний засварын ажил хийсэн нь

4. Цаг уурын Байтаг өртөөний байранд орон нутгийн санхүүжилтээр 8 сая төгрөгийн цахилгаан халаалт 3 өрөөнд хийлгэж, ажилчид өвлийн улиралд дулаан ажиллах нөхцөл бүрдлээ.




Зураг 3. Өрөөний цахилгаан халаалтын ажил хийгдсэн нь

5. Алтай сумын Ус судлал, цаг уурын харуулын техникч нар ажлын байрныхаа ажиллах нөхцөлийг сайжруулах үүднээс орон нутгийн сангаасаа нийт 27,011 сая төгрөгийн санхүүг шийдүүлж дараах ажлуудыг хийсэн: 1. Бодонч-Алтай ус судлалын харуулын ажиглалт хийдэг цэгийн тохижилтод шаардлагатай 7,743,000 төгрөгийн төсөв санхүүг орон нутгаасаа шийдүүлж тус харуулын ажиглалтын цэгийн далан уруу орох, гарах хэсэгт 20 метр урттай шатыг хамгаалалтын хашлага, цэг орчимд жижиг оврын авто машин зогсоол хийж тохижуулснаар харуулын техникчийн ажлын аюулгүй ажиллах орчин бүрдсэн. 2. Цаг уурын харуулын 2015 онд баригдаж ашиглалтад орсон конторын барилга засварлахад 15,280,000 сая төгрөгөөр барилгын доторх засвар хийх, дотор тохижилтонд сандал, ширээ, усны техникч зөөврийн компьютер авахад 3,980,000 сая төгрөгний ажлыг хийж, ажиллах орчин нөхцөлөө сайжрууллаа.



Зураг 4. Алтай сумын цаг уур, усны харуулуудын техникч нар ажиллах орчноо сайжруулахад хийсэн ажлуудыг хийсэн нь

6. Цаг уурын Манхан өртөөний хамт олон өөрсдөө 2.5 сая төгрөгийн төсөв санхүүгээ гаргаж нийгмийн хариуцлагын хүрээнд өртөөний байрыг цэвэр усны шугамд холбох, дотроо ариун цэврийн өрөөг тохижуулж, гадна талдаа бохир усны цооног гаргах ажлуудыг хийж, ажиллах орчин нөхцөлөө сайжрууллаа. Мөн өртөөний дотор талын урсгал засвар хийх, ажлын нормын хавцас шинэчлэх ажилд нийт 500,000 мянган төгрөгийн санхүү гаргаж ажиллалаа.



*Зураг 5. Хамт олноороо шийдсэн ажлууд*

7. Төвийн УМ-х салбарын хамт олон санхүүгээ дундаасаа гаргаж суудаг өрөөндөө засвар хийж, ажиллах орчин нөхцөлөө сайжруулав. Өрөөний хана таац замсагдах, гэрэл солих, хөшиг солих зэрэг тохижилтын ажлуудыг хийлээ.



*Зураг 6. УМ-ын хамт олон өрөөндөө засвар, тохижилт хийсэн нь*

Энэ онд салбар нэгжүүд ажиллах орчин нөхцөлөө сайжруулах ажилд ОНХС-аас болон хамт олноороо нийт 52,5 сая төгрөг шийдүүлж ажилласан байна.

1. Аймгийн төв оффисын барилгын агааржуулалт ердийн агааржуулалттай бөгөөд агаар сэлгэлт сайн, агаарын чийгшлийн хэмжээ 30-55 хувьтай байна. Мөн 9 өртөө 1 харуулын байрны агааржуулалт ердийн агааржуулалттай, агаар сэлгэлт сайн.

2. 2025 онд ажилчдын нормын хувцсыг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд зориулалтын хувцас хэрэгсэл баг авахад 4 сая төгрөгний санхүүг аймгийн ГЭБОН-н зөвлөлийн шийдвэрээр тус санхүүг шийдүүлсэн.



*Зураг 7 .Мэргэжлийн ангийн хувцас, хэрэгсэл шийдүүлсэн нь*

3. ЦУОШГазрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/831 дугаартай аюулгүй ажиллагааны заавар боловсруулах албан бичиг, УЦУОШТөвийн А/41 тоот аюулгүй ажиллагааны заавар боловсруулах ажлын хэсгийг салбар хариуцсан технологич инженерүүд өртөөдийн ахлах техникч нарыг хамарсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж тус ажлын хэсэг ажиллаж 2025 оны 12 сарын 31 нд УЦУОШТөвийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нийтлэг журам” батлагдаж нийт ажилчдад танилцуулж мөрдөж ажиллаж байна.

4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх салбарын ажиллах нөхцөл сайжруулах зорилгоор ажилчдын томилолт, автомашины бүрэн бүтэн шаардлага хангасан орчин бий болгох зорилгоор Аймгийн төсвөөс 20.0 сая төгрөгний санхүүжилт шийдвэрлүүлж ажиллаж байна.

---oOo---

**СҮХБААТАР АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

Сүхбаатар Аймгийн УЦУОШТөвийн харьяанд 13 сумын ус цаг уурын шинжилгээний 4 өртөө 9 харуул 49 хүний орон тоотой ажиллаж байна. Ус цаг уурын шинжилгээний 4 өртөө нь тасралтгүй 24 цагийн үйл ажиллагааг өөрийн байранд явуулдаг болно. Аймгийн төвийн оффис нь Баруун-Урт хотод байрлаж 500 м.кв байранд үйл ажиллагаа явуулж 24 албан хаагч ажиллаж, 1 албан хаагчид 4 м.кв ажлын байр ноогддог байна. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланд өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаа.

1. 2024, 2025 онуудад улсын хөрөнгө оруулалтаар Эрдэнэцагаан өртөөнд 67.8 сая төгрөг, байгууллагын төв оффист 152.3 сая төгрөгийн засвар хийж нийт 220.1 сая төгрөг зарцуулж, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан.
2. Аймгийн төв оффисын барилгын агааржуулалт ердийн агааржуулалттай бөгөөд агаар сэлгэлт сайн, агаарын чийгшлийн хэмжээ 35-45 хувьтай байна. Мөн Эрдэнэцагаан, Дарьганга, Баяндэлгэр өртөөдийн байрны агааржуулалт ердийн агааржуулалттай, агаар сэлгэлт сайн.
3. Ус цаг уурын байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг 2025 онд хийлгэж БОУАӨЯамнаас дүгнэлт авсан. Дүгнэлтээр аливаа зөрчил илрээгүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа.
4. Байгаль орчны шинжилгээний лабораторид ашиглаж байгаа татах шүүгээ нь Франц улсад үйлдвэрлэсэн агаарын таталтыг байнга хийж, өрөө тасалгааны агаарын сэлгэлтийг зохих түвшинд байлгадаг.
5. Тус төвийн БОШЛ-ын химийн бодис хадгалах байр, таталттай шүүгээг Баруун-Урт сумыг засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 11-ний А/328 захирамжаар тогтоож стандартын дагуу хадгалж байна.
6. Тус төвийн Дарьганга-Ганга, Дарьганга-Дуут усны харуулын техникчийг 2024 онд нормын хувцсаар хангасан бөгөөд 2025 онд усны завь, булгийн ундаргын урсац хэмжих автомат багажаар хангаж хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг бүрдүүлсэн. Дээрх тоног төхөөрөмж худалдан авахад 5.5 сая төгрөгийг олон улсын төслөөс шийдүүлсэн.
7. 2026 онд ажилчдын нормын хувцасны зардалд 6.3 сая төгрөг батлагдаж, нийт 49 албан хаагчдад оффис болон дулааны улиралд өмсөх хувцсаар хангаж, цаг агаар зориудаар нөлөөлөх экспедицийн 12 албан хаагчдад өвөл, зуны улиралд өмсөх хувцсаар хангасан байна.
8. 2025 онд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 40 заалттай ажлын төлөвлөгөө баталж үүнээс эрүүл ахуйн чиглэлээр 3 төрлийн сургалт авч зохион байгуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай байна.
9. Ус цаг уурын салбарын тасралтгүй, шуурхай ажиллагааны хүрээнд ээлжид 33 хүн ажилладаг бөгөөд 2025 онд шөнийн нэмэгдэл, баяр ёслолын нэмэгдэлд 18,768,656.30 төгрөг, илүү цагийн нэмэгдэлд 28,611,518.18 төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 112,197,134.61 төгрөг зарцуулсан байна.
10. 2025 онд 20 албан хаагчийг улсын 2 дугаар эмнэлэгт эрүүл мэндийн багц үзлэгт хамруулж, байгууллагаас 3 сая төгрөг зарцуулсан. Мөн нийт ажилчдыг өрхийн эрүүл мэндийн төвийн багц үзлэгт үнэ төлбөргүй хамруулж, ажилчдын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийг тогтоож, нийт ажилчдын 90 гаруй хувь нь харааны эмгэгтэй болохыг тогтоосон.

Эрүүл мэндийн үзлэгийн тайлангийн дүгнэлт:

2025 онд төвийн бүх ажилчид харьяалагдах багынхаа өрхийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ өгч хамрагдсан байна. Мөн Улсын 2-р төв эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих төвд нийт 20 хүн ЭМ-н урьдчилан сэргийлэх төлбөртэй багц үзлэг, шинжилгээнд 2025 оны 06 сарын 19-ны өдөр хамрагдсан байна. Шинжилгээний дүгнэлтээр ажилчдын дунд 8 бүлгийн 20 гаруй эмгэг байгаагаас зонхилон Д витамин, дуагдал, хеликобактери, зээрэнцгийн эмгэг тус тус эзэлсэн ба ажилчдын картад эмчилгээ зөвлөгөөг хавсаргасан байна.


ЦУОШГазраас 2026 оныг "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа технологи шинэчлэлийн жил" болгон зарласантай холбогдуулан тус төвөөс 32 заалттай жилийн төлөвлөгөө баталж үүнээс хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 16 ажил төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана. Фото зургийг хавсаргав.



Төв конторын засвар



Эрдэнэцагаан өртөөний засвар



Нормын хувцас

---oOo---

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Хөтөлбөр хэрэгжүүлэх 5 бүлэг, 26 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан төвийн дарга баталж хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

2025 онд Цаг уур, орчны шинжилгээний газраас баталсны дагуу 83 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан бөгөөд Засгийн газрын тогтоолыг үндэслэн төвийн даргын тушаалаар албан хаагчдын цалин хөлсийг оны эхэнд шинэчлэн баталсны дагуу тооцон сар бүрийн 25-ны дотор зохих хууль, журмын дагуу олгож байна. 2026 оны 1 сарын 01-ний өдрөөс 9%-ийн цомхотголыг хэрэгжүүлж газрын даргын шинэ бүтцээр 75 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Албан хаагчдад цалингийн сүлжээний дагуу үндсэн цалин дээр албан хаагчдын цалин нэмэгдүүлэх, урамшуулал олгохдоо ажилласан жил болон ажлын үр дүнг харгалзан тухайн албан хаагчийн мэргэжлийн түвшин, ур чадвартай уялдуулан, төрийн алба хаасны нэмэгдэлд нэмэгдэл хөлсийг тооцон олгосон.

Эрүүл мэндийн байдал, ар гэрийн гачигдлыг харгалзан үзэж дотоод журмын дагуу даргын тушаалаар ажлын 5 хоногоос 3 сар хүртэлх хугацаатай цалинтай чөлөөг олгосон.

Хөдөлмөрийн тухай хуулийн шиэнчилсэн найруулгатай холбоотой эхнэр нь амаржсан албан хаагчдад ажлын 10 хоногийн цалинтай чөлөө олгов.

Хөнгөлөлттэй цагаар ажилласан бүх ажилчдын цалинг ажилласнаар тооцож олгосон.

Улаанбаатар хотод болон хөдөө орон нутагт албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдыг тухай бүр албаны унаагаар хангасан.

Хууль тогтоомжийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид нийт 34,4 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж олгосон.

Албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгслээр хангагдсан. Лабораторийн албан хаагчдыг нэг удаагийн бээлий, маск, бусад хортой нөхцөлийн хэрэгслээр хангасан.



Ажлын байрны орчин, ажиллах нөхцөлийг сайжруулж өрөө тасалгаануудад засвар хийж, халаалт, дулаан, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны хангамжийг хэвийн хэмжээнд явуулсан байна.

Сумдын салбаруудын галын сарай шинэчлэн тохижуулсан.



Хөдөлмөр хамгаалалын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор 2 өрөөний ажиллах нөхцөл хүнд байсан тул засварыг өөрсдийн хүчээр хийж дуусгасан.



2025 оны 8 сард ОХУ-д Албан хаагчдыг цэвэр агаарт гаргах, аялалд хамруулах зэрэгт Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран хөрөнгө шийдвэрлэж ажилласан.



Мөн байгууллагын гадаад үзэмжийг сайжруулахад анхаарч, гадна хашаа шинээр хийж, засварлаж байна. 2026 оны 4 дүгээр 01 өдөр хүртэл дусгах болно.



Одоогийн байдлаар Дэлүүн, Булган өртөөний хашаа татах нийт 11,0 сая төгрөгийг тус тус сум хөгжүүлэх сангаас шийдвэрлүүлсэн.



Ногооннуур өртөөний халаалтын 8,0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас шийдвэрлүүлэн ажиллав.



Дэлүүн сумын цаг уурын өртөөний засварт тендер зарлагдаж “Ничино Эйч Ар” компани шалгарч 36,5 сая төгрөгөөр их засвар бүрэн хийгдэж дууссан. Сумаасаа 6,0 сая төгрөг шийдвэрлүүлж хашаа татсан.



Байгууллагын ҮЭХ-той хамтран төвийн 40 албан хаагчдыгаа Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахаар Нэгдсэн эмнэлэгтэй хийсэн гэрээний дагуу 2026 оны 5 дугаар сард бүрэн хамрагдуулахаар гэрээ хийсэн. Үүнд хэвлийн эхо оношилгоо, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, дотрын эмчийн үзлэг гэх мэт. БОШЛ-ийн 3 албан хаагчид хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдлийг төсөвтэй уялдуулан 2025 оны 1-12 дугаар 10 хувиар тус тус олгож байна. Төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан танхимын сургалт 25, цахимаар 15 сургалтад оролцсон ба үүнээс ажлын байран дахь сургалт тогтмол хамааруулж байна. Тэсэрч дэлбэрэх бодистой ажиллах тусгай чиг үүргийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж 2 жил ажиллах эрх авсан.

Ахмадын танхимын засвар хийгдэж нийт 1,2 сая төгрөг зарцуулан Дэлхийн ус, цаг уурчдын өдрөөр нээлт хийж ахмадуудад гарын бэлэг гардуулсан.



2025 онд дараах хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасан. Үүнд:


- Өвлийн хувцас /хос/ - 3 ширхэг
- Усны гутал 11 - ширхэг
- Духны гэрэл 11 ширхэг тус тус худалдан авсан.

Ажлын байрны нөхцөлийн талаар төвийн албан хаагчдаас судалгаа авч, ажлын орчныг сайжруулах дараах арга хэмжээнүүдийг авч, зохион байгуулж ажиллалаа.

- Сумдын албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааврыг ашиглаж хэвшүүлэх үүднээс тогтмол гарын үсэг зуруулж, сар бүрийн эхний 5-ны дотор цахимаар зурагжуулан авч бүртгэлцүүлж байна.
- Албаны дотоод хаалттай цахим хуудсанд ХАБЭАхуйн хууль, заавар зөвлөмжтэй холбоотой мэдээллийг тогтмол оруулж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/08 дугаар захирамжийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр судалгааны ажлын хэрэгсэлд 16,1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Мөстөл судлал, Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц, гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнд

хувцас, багаж, цүнх, аранз, анхан шатны эмнэлгийн тусламжийн хайрцаг, гар чийдэн, радио гэх мэт хэрэгслийн хамт олгосон. Авто машинуудад шаардлагатай сэлбэг хэрэгслийн үнийн судалгааг хийж, урсгал засвар хийгдсэн. Үүнд: Аймагас 1,5 сая төгрөг шийдвэрлүүлэж энэ жилийн засварт хэрэгжүүлэх болно.

- Хээрийн нөхцөлд ажиллах экспедицийн бүрэлдэхүүнийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээ бүрэн ашиглаж байна.



6 өртөөний ажлын өрөөнд угаарын хийгээс урьдчилан сэргээх зорилгоор мэдрэгч багажаар хангасан.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Тус төв нь ЦУОШГ-ын даргын 2024.08.04-ний өдрийн А/162 тушаалаар 76 албан хаагчтай ажилладаг.

Аймгийн хэмжээнд 18 сум 2 тосгонд Ус цаг уур, хөдөө аж ахуйн 5 өртөө, 14 харуул мөн ус судлалын 5 харуулд 44 техникч, аймгийн төвд 32 салбар хариуцсан инженер, техникч, бусад албан хаагч нийлээд 76 орон тоотой ажиллаж байна.

Ус цаг уурын шинжилгээний 6 өртөө болох Тонхил 2012 он 82м2, Хөхморьт 2012 он 82м2, Баян Тоорой 2008 он 48м2, Алтай сум 1987 он 86 м2, Бугат сум 1987 он 59 м2, талбайтай, Алтай станц нь аймгийн төвийн 12.21 м2 талбайтай нэг өрөөнд тус тус 3 дугаар зэргийн барилга байгууламжийн галд тэсвэрлэлттэй барилгад 24 цагийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Аймгийн төвийн оффис нь Алтай хотод байрлаж 261 м.кв байранд үйл ажиллагаа явуулж 24 албан хаагч ажиллаж, 1 албан хаагчид 8 м.кв ажлын байр ноогддог ба уг 3 дугаар зэргийн барилга байгууламжийн галд тэсвэрлэлттэй, эдэлгээний 3 зэргийн барилгад үйл ажиллагаагаа явуулж байна.

### Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланд өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажил

1. Сумдын өртөөдийн албан хаагчдын ажиллах орчин сайжруулах зорилгоор 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бугат өртөөнд 61.2 сая төгрөг, Тонхил өртөөнд 56.2 сая төгрөг нийт 117,4 сая төгрөгөөр дулааны дулааны шугамын ажлыг хийж улсын комисст хүлээлгэн өгсөн.





2. БОШЛаборатори нь тусгай байргүйн улмаас төвийн албан хаагчдын ажлын байрны 1 өрөөнд үйл ажиллагаа явуулан химийн бодис байгууллагаас үнэртэж ажиллах орчин нөхцөл хүнд байсан. Иймээс байгууллагын гадна талын хуучин барилгыг 2024 онд 43.6 сая төгрөгөөр засварлаж лабораторийг тусад нь гаргаж ажиллах орчин сайжруулсан.





3. Тус төвийн БОШЛ-ын химийн бодис хадгалах өрөөг байгууллагын гадна талд тусгай агаар солилцох сэнстэй, химийн бодис ууршихаас сэргийлэн нарны тусгалаас хамгаалсан тусгай өрөөнд хадгалж хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.



4. БОШЛ-ийн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэж 2025.03.24-ны өдрийн БОУАӨ-н сайдын тушаалаар зөрчилгүй зөвлөмж авч 2025.10.21-ний Дугаар:0000280 химийн бодис ашиглах зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай авч лабораторийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

5. Жил бүр Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бүрэлдэхүүнийг Монгол даатгал ХХК-д гэнэтийн ослын даатгалд хамруулж хэвшсэн.



6. Аймгийн төвийн ажлын байр нь 2008 оноос хойш урсгал засвар хийгдээгүйн улмаас хана таазнаас борооны дусал гоожих, шохой унах зэрэг ажлын байрны шаардлага

хангахгүй нөхцөл үүссэн байсныг 2024 онд 36.5 сая төгрөгөөр урсгал засвар хийж ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.



7. Баян-тоорой өртөөний албан хаагчид өөрсдөө хавар, намар, өвлийн улиралд ажлын байраа галлаж эрүүл ахуйн шаардлага хангахгүй хүнд нөхцөлд ажилладаг байсныг 2025 онд 6.8 сая төгрөгөөр дулааны шугамын ажлыг хийж халаалтын асуудлыг шийдвэрлэсэн.





8. Аймгийн төв болон өртөөдийн байрны агааржуулалт хэвийн агаарын чийгшил 30-48 хувьтай байна.

9. 2025 онд Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн 5 албан хаагчид 625,000 төгрөгөөр хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцсаар хангасан.



10. 2024, 2025 онд тухайн жилийн төсөвтөө багтаж ус судлалын харуул болон экспедицийн бүрэлдэхүүнд усны гутлаар хангалт хийсэн.



11. Ус цаг уурын салбарын тасралтгүй, шуурхай ажиллагааны хүрээнд ээлжид 35 хүн ажилладаг бөгөөд 2025 онд шөнийн нэмэгдэлд 67,605,551 төгрөг, баяр ёслолын нэмэгдэл болон илүү цагийн нэмэгдэлд 177,265,965 төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 208,100,000 төгрөг зарцуулсан байна.

12. 2023 оноос хойш жил бүр албан хаагчдыг “Аймгийн +80 хөтөлбөр”-ийн хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран эрт илрүүлэгд бүрэн шинжилгээнд хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгээр албан хаагчдын 80-аас дээш хувь нь харааны өөрчлөлттэй. Мөн уламжлалын эмнэлэгтэй хамтран өдрийн цагаар албан хаагчдыг бариа засал, зүү төөнүүрийн эмчилгээнд бүрэн хамруулсан.



13. ЦУОШГ-ын даргын 2025.10.06-ны өдрийн А/214, 2026.11.18-ны өдрийн А/252 дугаар тушаал, 2026.11.20-ны өдрийн 01/831 албан тоотын хэрэгжилтийг ханган төвийн 30 албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам, зааварчилгааг танилцуулсан. Мөн 2026 оныг ХАБЭА-н жил болгосонтой холбогдуулан 25 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

14. Төвийн 30 албан хаагчдад албаны хурлаар болон сумдын өртөө харуулын 44 техникчдэд онлайнаар ХАБЭА-н салбарын хуульд өөрчлөлт оруулах саналыг авсан. Мөн шинэчлэн гарсан хуулийг танилцуулан баталгаажуулан холбогдох хэлтэст хүргүүлсэн.

15. ХАБЭА-н чиглэлээр 2 сургалтыг аймгийн төвийн албан хаагчдад танхимаар, сумдын өртөө харуулын техникч нарт цахимаар Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулсан.







16. ЦУОШГ-ын даргын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам, зааварчилгаа батлах тухай А/252 тушаал, 2026.03.06-ны Ус, цаг уур орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм заавар батлах тухай тушаалыг танилцуулан, БОШЛ-н инженер, техникч, урьдчилан мэдээлэхийн инженерүүд, өртөө харуулын техникч нарт ажлын байран дахь зааварчилгаа өгөн өдөр тутамд хяналт тавин ажиллаж байна.





Ажлын байран дахь давтан зааварчилгааны бүртгэл

№	Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал	Зааварчилгаа өгсөн хүний гарын үсэг	Давтан зааварчилгаа өгсөн шалтгаан	Зааварчилгааны сэдэв	Он сар өдөр	Ажилтны овог нэр, ажил, албан тушаал БОШЛ-ийн технологич инженер, инженерүүд	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг
1.	УЦУОШТ-н дарга Н.Алтантуяа		Албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Цаг үүр орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/252 дугаар тушаалын дагуу "ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ"-тай танилцан холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах	2026.01.14	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа
2.	УЦУОШТ-н дарга Н.Алтантуяа		Албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Ус, цаг үүр орчны шинжилгээний салбарын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журамын 9-р бүлгийн /Байгаль орчны шинжилгээний лабораторид аюулгүй ажиллах/ заалтуудыг өдөр тутмын ажилдаа мөрдөн аюулгүй ажиллагааг ханган ажиллах	2026.01.14	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа
3.	УЦУОШТ-н дарга Н.Алтантуяа		Албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Ус, цаг үүр орчны шинжилгээний салбарын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журамын 5-р бүлгийн /Компьютер, холбооны төхөөрөмж дээр аюулгүй ажиллах/ заалтуудыг өдөр тутмын ажилдаа мөрдөн аюулгүй ажиллагааг хангах ажиллах	2026.01.14	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа
4.	УЦУОШТ-н дарга Н.Алтантуяа		Албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Өрөө тасалгаанд тавигдах галын аюулгүйн шаардлагыг өдөр тутмын ажилдаа мөрдөн аюулгүй ажиллагааг ханган ажиллах	2026.01.14	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа	Д.Сарантуяа Ц.Болормаа С.Янжмаа

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ (ЦАЗН) ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2009 оноос эхлэн тасралтгүй явуулж байна. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг үе шаттайгаар сайжруулан ажиллаж байна.

### Хөдөлмөрийн нөхцөлийн онцлог

Экспедицийн бүрэлдэхүүн нь цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хүйтэн зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлд гадаа орчинд ажилладаг онцлогтой. Мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь цаг үеийн нөхцөл байдал харгалзахгүй явагддаг тул шөнийн ээлжинд ажиллах, нойр дутуу, биеийн ачаалал ихтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага үүсдэг.

### Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

ЦАЗН үйл ажиллагаанд оролцогч албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, ажлын нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

1.2024 онд Говьсүмбэр Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 10 сая төгрөгний хөрөнгө оруулалт авч авто машины тоног төхөөрөмж, экспедицийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл, стандартын дагуу аюулгүй “пуужин” хадгалах сейф болон бусад техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн тусламж дэмжлэг авч ажилласан.


2.2023 оны 3 дугаар сард Цаг уур, орчны шинжилгээний газрын Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсээс хуваарилсан HUAYUN брэндийн цаг уурын хэмжилтийн



төхөөрөмжийг хүлээн авч, ажиллагааг шалган туршилтын тоололт хийж бэлэн байдлыг

ханган ажиллалаа. Улмаар тус төхөөрөмжийг “Мицубиши L200” маркийн автомашинд суурилуулж, хээрийн нөхцөлд цаг уурын хэмжилт хийх боломж, нөхцөлийг сайжруулсан. 3.2024 онд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зааврын зургаадугаар бүлгийн 11 дэх заалтад заасны дагуу борооны пуужин, сум тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангах ажлын хүрээнд 03-33 ГСА улсын дугаартай автомашиныг аюултай ачаа тээвэрлэх стандарт шаардлагад нийцүүлэн бэлтгэж, бүрэн ханган ажилласан. 4.2024 онд хамгаалалтын малгай, усны гутал, борооны цуваар хангагдсан.

Хөдөлмөр хамгааллын хувцасаар хангагдахаас өмнө



Хөдөлмөр хамгааллын хувцасаар хангагдсаны дараа



Автомашинг аюултай ачаа тээвэрлэх стандарт шаардлагад нийцүүлэн тоногдсон



**ДАРХАН-УУЛЫН АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН  
ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ (ЦАЗН)  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ**

Дархан-Уул аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарт зориудаар нөлөөлөх (ЦАЗН) үйл ажиллагааг 2011 оноос эхлэн тасралтгүй явуулж байна. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг үе шаттайгаар сайжруулан ажиллаж байна.

**Хөдөлмөрийн нөхцөлийн онцлог**

Экспедицийн бүрэлдэхүүн нь уулархаг өндөр газарт цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хүйтэн зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлд гадаа орчинд ажилладаг онцлогтой. Мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн оройн 20:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд явагддаг тул шөнийн ээлжинд ажиллах, нойр дутуу, биеийн ачаалал ихтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага үүсдэг.

**Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**


ЦАЗН үйл ажиллагаанд оролцогч албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, ажлын нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн байна.

1. Хээрийн ажиллагаанд оролцогч албан хаагчид өмнө нь хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангагдаагүй ажиллаж байсан тул 2019 онд өвөл, хавар, намрын улиралд зориулсан дотортой хөдөлмөр хамгааллын хувцасаар бүрэн хангаж, ажлын нөхцөлийг сайжруулсан.
2. 2023 оны 3 дугаар сард Цаг уур, орчны шинжилгээний газрын Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсээс хуваарилсан HUAYUN брэндийн цаг уурын хэмжилтийн төхөөрөмжийг хүлээн авч, ажиллагааг шалган туршилтын тоололт хийж бэлэн байдлыг ханган ажиллалаа. Улмаар тус төхөөрөмжийг “Мицубиши L200” маркийн автомашинд суурилуулж, хээрийн нөхцөлд цаг уурын хэмжилт хийх боломж, нөхцөлийг сайжруулсан.
3. 2024 оноос эхлэн экспедицийн бүрэлдэхүүнийг гэнэтийн ослын даатгалд хамруулж, ажилтнуудын нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.
4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зааврын зургаадугаар бүлгийн 11 дэх заалтад заасны дагуу борооны пуужин, сум тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангах ажлын хүрээнд 01-74 ДАА улсын дугаартай автомашиныг аюултай ачаа тээвэрлэх стандарт шаардлагад нийцүүлэн бэлтгэж, бүрэн ханган ажилласан.
5. 2024 оноос эхлэн экспедицийн бүрэлдэхүүнийг гэнэтийн ослын даатгалд хамруулж, ажилтнуудын нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.
6. 2024 онд хамгаалалтын малгай (каска)-аар бүрэн хангаж, 2025 онд усны гутал, борооны хувцсаар хангагдсан.

Хөдөлмөр хамгааллын хувцасаар хангагдахаас өмнө




Хөдөлмөр хамгааллын хувцасаар хангагдсаны дараа



Шөнийн цагаар ажиллагаа явуулах үе



Автомашинг аюултай ачаа тээвэрлэх стандарт шаардлагад нийцүүлэн тоногдсон



Автомат станцийг авто машин




## ГОЛЫН УСНЫ ГОРИМЫН АЖИГЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙХ ҮЕИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

### **Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв**

2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 01/334 тоот хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хариу арга хэмжээ авах үүсч болзошгүй эрсдэлүүд:

Инженер, технологийн арга хэмжээ

1. Ажлын байрны аюулгүй байдал, эмх цэгцийг хангах
2. Усны харуулын ажлын байранд ажиглагчийн амь насны эрсдэлийг бууруулах зорилгоор Хараа дархан усны харуулын усны өнгөрөлт хэмжих зориулалттай ГР-70 багажийн ган татлагын тулгуурыг шинэчлэж тохижуулсан




Зураг 1. Харуулын хуучин байрыг шинэчлэж тохижуулсан байдал



Зураг 2. Ажиглалтын цэг усны түвшин хэмжих эгц эрэгтэй хэсэгт төмөр бариултай шат хийж тохижуулсан

3. ХХ-ын хувцас /усны гутал, аврах хантааз, аврах бүс, ажлын бээлий гэх мэт/ хамгаалах хэрэгсэл өмсөх / дутагдалтай /



Зураг 3. Мөс цоолох өрөм /10мм/, Аврах хантааз

Усны харуулын 3 ажиглагчийг мөсний өрөмөөр хангаж аюулгүй ажиллагааг хагасан

4. Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан нэмэлт хамгаалах хэрэгсэл хэрэглэх /борооны цув, эсгий гутал, ослын тэмдэг гэх мэт /



Зураг-4 Оросын холбооны улсад үйлдвэрлэсэн өвлийн усны гутал / Усанд норохгүй, чийг татдаггүй хөнгөн зөөлөн /

Намар, өвлийн ажиглалт, хэмжлийн үеийн ХААЗааварчилгаа

Ус судлалын ажиглалт, хэмжлийн ажил хийхийн өмнө:

- Бүх багаж, төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг заавал шалгаж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засуулах, шалгалт баталгаажилт хийлгэх арга хэмжээг яаралтай авч ажил гүйцэтгэнэ.



Зураг 1. Мөсний үзэгдэлтэй үед усны өнгөрөлт хэмжиж байгаа нь

- Ус судлалын ажиглагч өнгөрөлт хэмжлэгийн үед туслан ажиллаж байгаа хамтран ажиллагчийн аюулгүй байдлыг хангана. /гэр бүлийн хүн буюу туслагчид анхааруулга, санамж өгөх зэрэг/
- Хэмжлийн багаж төхөөрөмжид хүрэх шат, замыг тогтмол цэвэрлэж, халтиргаагүй байлгах / хуурай элс, шороо цацах, гишгүүр тавих/
- Өвлийн улиралд ус судлалын харуулын ажиглагч нар мөсөн дээр, чийгтэй нойтон газар удаан ажилласнаас бөөр нурууны өвчтэй болох эрсдэлтэй байна

Ус судлалын ажиглалт, хэмжлийн ажил хийх үед:

- УС-ын шинжилгээний ажил нь цаг, минутаар хэмжигддэг тул хугацаанд баригдах шалтгаантайгаар яарах, огцом хөдөлгөөний улмаас санамсаргүйгээр усанд унах, мөсөн дээр хальтирч унах, гэмтэх зэргээс болгоомжлох
- Ажиглалт, хэмжлийн стандарт ажиллагааны заавар, хэмжлийн дараалал барьж ажиллаагүйгээс /туршлага, арга барил дутмагаас/ усанд унах, багаж хэрэгсэл эвдлэх, хагалах үүдлээр бэртэх гэмтэхээс сэргийлэх

## Гол чөлөөтэй үед усны түвшин, усны өнгөрөлт хэмжих



Зуны хур борооны үертэй үед усны өнгөрөлт хэмжиж байгаа нь:

- Тайлбар: Зураг -1 баруун гар талаас ус судлалын харуулын ажиглалтын цэг  
 Зураг- 2 голын усны түвшин ОЖД-ийн орчим / 229см /  
 Зураг- 3 гол үерийн аюултай түшнийг давж үерлэсэн байдал  
 /харуулын цэг гүүр хур борооны үерт усанд автсан байна /  
 Зураг-4 гол үерийн түвшинд хүрсэн үед усны өнгөрөлт хэмжиж байгаа нь

### 2025 ОНД УС СУДЛАЛЫН ДАРХАН ӨРТӨӨНД ХАБ-ЫГ ХАНГАХАД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая төгрөг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хөрөнгө оруулалт	Төсөвт өртөг
1	Ус судлалын харуулын байр	Улсын төсөв	33,596,350
2	Харуулын байрны хамгаалалтын хашаа	Орон нутгийн хөрөнгө оруулалт	777,000
3	Мөсний өрөм /оху/ 10мм	Давсан орлого	780,000
4	Өвлийн усны гутал /оху/	Давсан орлого	480,000
5	Хамгаалалтын шат, шатны бариул	Давсан орлого	50,000
<b>Нийт</b>			<b>35,683,350</b>

----oOo----

## **ДОРНОД АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 онд ур чадварын нэмэгдэлд 95,760.0 мянган төгрөг, шөнө цагийн нэмэгдэлд 24,228.0 мянган төгрөг, Илүү цагийн нэмэгдэлд 4,260.0 мянган төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 202,905.3 мянган төгрөг, 1,2,3,4 дугаар улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд 173,476.6 мянган төгрөгийг бусад нэмэгдэлд 742,260.0 төгрөгийг цалингийн төсвөөс зарцуулсан.

**Хөдөлмөр хамгаалалын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор борооны ус нэвчиж, гоождог, ажлын 5 өрөөний ажиллах нөхцөл хүнд байсан тул байгууллагын дээврийн 360м.кв талбайн засварыг өөрсдийн хүчээр хийж дуусгасан. Мөн байгууллагын гадаад үзэмжийг сайжруулахад анхаарч, үүдний гадна фасадыг шинээр хийж, засварласан. Нийт тоног төхөөрөмж урсгал засварын зардалд 33,0сая төгрөг зарцуулсан.

Дашбалбар, Онон өртөөний цахилгаан утас, тоолуур шинэчлэх, гадна гэрэлтүүлгийг шинэчлэхэд 585,0 мянган төгрөг, Синоптикийн өрөөний гэрэлтүүлгийг сайжруулсан 99,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Байгууллагын ҮЭХ-той хамтран төвийн 29 албан хаагчидийг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахаар Шонымэд эмнэлэгтэй хийсэн гэрээний дагуу 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр бүрэн хамрагдсан. Үүнд хэвлийн эхо оношилгоо, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, дотрын эмчийн үзлэг гэх нэр төрлийн шинжилгээнд нийт 3.239.000 төгрөгийг зарцуулсан байна. БОШЛ-ийн 3 албан хаагчид хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдэлийг төсөвтэй уялдуулан 2025 оны 1-12 дугаар 10 хувиар тус тус олгож байна. Засгийн газар, дээд байгууллага, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан танхимын сургалт 53, цахимаар 9 сургалтад оролцсон ба үүнээс ажлын байран дахь сургалт 15, мэргэшүүлэх сургалт 21, бусад сургалтын тоо 26 байна.

Цаг уур орчны шинжилгээний газар болон стандарт хэмжил зүйн газрын хамтарсан шалгалт тохируулгын ажилтаны эрх олгох сургалтанд хамрагдаж 2 жилээр эрх авсан.

Тэсэрч дэлбэрэх бодистой ажиллах тусгай чиг үүргийн сургалтад 3 албан хаагч хамрагдаж 2 жил ажиллах эрх авсан.

5 өртөө, 20 харуулын ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, сургалт, семинарийн үеийн тасралтгүй ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, зохицуулах, тасралтгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөн БОЭТөвийн цусны тасагт 10 албан хаагч цусны бүлэг тодорхойлуулж, цусны нарийн шинжилгээ өгсөн.

2025 оны дараах хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасан. Үүнд:

Өвлийн хувцас /хос/ -25 ширхэг

Борооны цув -25 ширхэг

Усны гутал 15 –ширхэг

Усны комбинзон -13 ширхэг

Духны гэрэл 26 ширхэг тус тус худалдан авсан.

Ажлын байрны нөхцлийн талаар төвийн албан хаагчдаас судалгаа авч, ажлын орчныг сайжруулах дараах арга хэмжээнүүдийг авч, зохион байгуулж ажиллалаа. Сумдын албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааврыг ашиглаж хэвшүүлэх үүднээс тогтмол гарын үсэг зуруулж, сар бүрийн эхний 5-ны дотор цахимаар зурагжуулан авч бүртгэлжүүлж байна..

Албаны дотоод хаалттай цахим хуудсанд ХАБЭАхуйн хууль, заавар зөвлөмжтэй холбоотой мэдээллийг тогтмол оруулж байна.

Авто машинуудад шаардлагатай сэлбэг хэрэгслийн үнийн судалгааг хийж, урсгал засвар хийгдсэн. Үүнд: L200 машинд урд, хойд амортизатор, урд наклад, салоны агаар шүүгч, маслын шүүр, масло, 4 дугуй /2,554,000 төг/, MUSSO автомашинд ир гэрэл хос, урд, хойд амортизатор, хагас гол сальник, чагтан гол, рулийн аппарат, доод гар, аккумулятор /2,552,000төг/

Хээрийн нөхцөлд ажиллах экспедицийн бүрэлдэхүүнийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэлээ бүрэн ашиглаж байна.

2025 онд Монгол даатгалын ХЧТХ, Гэнэтийн ослын даатгалд нийт 65 албан хаагч нийт 3,145,800 төгрөгөөр даатгуулсан. 2026 онд 57 албан хаагч 1,781,400 төгрөгийн даатгалд 3 дугаар сард хамрагдсан.

**1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх.** Бусад Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны инженерүүдтэй санал солилцож, тайланд нэгдсэн байдлаар тусгасан.

Байгууллагад хийгдсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, түүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжид (4.1–4.4) “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль болон MNS 5080:2023 стандартын шаардлагад нийцүүлэн ажлын байрны эрсдэлийг бууруулах, ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гэвч эдгээр зөвлөмж, арга хэмжээг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ажилладаг **ерөнхий инженер, жолооч-техникч** нарын ажлын байранд бодитойгоор хэрэгжүүлсэн байдал хангалтгүй, зарим тохиолдолд огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах инженер, технологийн арга хэмжээ (агааржуулалт, хамгаалах хэрэгсэл, ажлын байрны стандарт орчин бүрдүүлэх) нь хээрийн нөхцөлд ажилладаг дээрх албан тушаалтнуудад бодитоор хүрээгүй;
- Тэсэрч дэлбэрэх аюултай материалтай харьцан ажилладаг онцлогт нь тохирсон **аюулгүй ажиллагааны тусгай тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл, дуу чимээний хамгаалалт** бүрэн хангагдаагүй;
- Алслагдсан бүс нутагт олон хоногоор ажиллах үед амрах байр, эрүүл ахуйн наад захын нөхцөл, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ дутмаг;
- Ажилтны эрүүл мэндийн үзлэг, хяналт, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тандалт нь тухайн ажлын онцлогт нийцсэн түвшинд зохион байгуулагдаагүй;
- Шөнийн ээлж, урт хугацааны хээрийн ажилтай холбоотой **ажлын цагийн зохицуулалт, илүү цагийн нөхөн олговор, амралтын нөхцөл** бүрэн шийдвэрлэгдээгүй;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, дадлага, эрсдэлийн үнэлгээ нь бодит ажлын байр (үүлэнд нөлөөлөх ажиллагаа, пуужин ашиглалт)-д тулгуурлан хангалттай хийгдээгүй;
- Саатсан пуужинг аюулгүй болгох зэрэг **өндөр эрсдэлтэй ажиллагаанд ажилтныг хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээ** тодорхой бус, хэрэгжилт сул байна.

Иймд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр гарсан дүгнэлт, зөвлөмжүүд нь цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны инженер, жолооч-техникчийн ажлын байрны бодит нөхцөлд **хэрэгжээгүй буюу хангалтгүй хэрэгжсэн** гэж дүгнэж байна.

**ДҮГНЭЛТ** Дээрх нөхцөл байдлаас үзэхэд тухайн ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангахгүй байгаа бөгөөд ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр хэвээр байна.

Иймд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны **ерөнхий инженер, жолооч-техникч** нарын ажлын байрыг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамааруулан үзэх, мөн өмнө

гарсан зөвлөмжүүдийг бодитоор хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## **ХӨДӨЛМӨРИЙН ХҮНД НӨХЦӨЛД ХАМААРУУЛАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ ҮНДЭСЛЭЛ ТАЙЛАН**

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бэлчээр болон газар тариалангийн бүс нутгийн хөрсний чийгийг нэмэгдүүлэх, ган, зудын эрсдэлийг бууруулах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийн үед дэмжлэг үзүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой, онцлог чиг үүрэг бүхий үйл ажиллагаа юм.

Энэхүү үйл ажиллагаанд оролцож буй хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн бие бүрэлдэхүүнд ажилладаг ерөнхий инженер, жолооч-техникч нар нь дараах онцгой нөхцөл, эрсдэл бүхий орчинд үүргээ гүйцэтгэж байна. Үүнд:

**1. Цаг уурын хүнд нөхцөлд ажиллах онцлог:** Экспедицийн бүрэлдэхүүн нь жилийн дөрвөн улиралд, цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хэт халуун болон хэт хүйтэн зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлд тасралтгүй ажилладаг. Ялангуяа үүлний хөгжлийн онцлогоос шалтгаалан ажиллагаа ихэвчлэн оройн 20:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд явагддаг тул шөнийн ээлжинд, нойр дутуу, биеийн ачаалал ихтэй нөхцөлд ажиллах шаардлага үүсдэг.

**2. Тэсэрч дэлбэрэх аюултай материалтай харьцах:** Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд G бүлгийн 1.4 болон F бүлгийн 1.1 ангиллын бөөнөөр тэсэрч дэлбэрэх өндөр аюултай материалыг (пуужин, цэнэг) ашигладаг. Ерөнхий инженер, жолооч-техникч нар нь эдгээр материалыг:

- Тээвэрлэх
- Ачиж буулгах
- Хадгалах, хамгаалах
- Ашиглах
- Аюулгүй ажиллагааг хангах бүх үе шатанд шууд харьцаж ажилладаг бөгөөд энэ нь осол, эрсдэлийн өндөр магадлалтай, онцгой анхаарал шаардсан ажил юм.

**3. Алслагдсан болон урт хугацааны хээрийн нөхцөл:** Экспедицийн үйл ажиллагаа нь ихэвчлэн хүн ам суурьшаагүй, алслагдсан бүс нутагт явагддаг бөгөөд хэдэн зуугаас мянган километрийн замыг тэсэрч дэлбэрэх аюултай ачаатай туулж, хээрийн нөхцөлд байрлан ажилладаг. Энэ нь зам тээврийн осол, байгалийн гэнэтийн аюул, холбоо мэдээллийн хязгаарлагдмал байдал зэрэг эрсдэлийг дагуулдаг.

**4. Дуу чимээ болон физик нөлөөлөл:** Пуужин харвах үед үүсэх хүчтэй тэсрэлтийн дуу чимээ нь хүний сонсголын эрхтэнд сөргөөр нөлөөлөх, урт хугацаанд мэргэжлээс шалтгаалах өвчлөл үүсгэх эрсдэлтэй.

**5. Онцгой эрсдэлтэй шууд оролцоо:** Пуужин харвалгүй үлдсэн (саатсан) тохиолдолд ерөнхий инженер нь өөрийн биеэр очиж, аюулгүй болгох ажиллагааг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь амь насанд шууд аюул учруулж болзошгүй өндөр эрсдэлтэй ажилбар юм.

**ДҮГНЭЛТ** Дээр дурдсан нөхцөл байдлуудаас үзэхэд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ажиллаж буй ерөнхий инженер, жолооч-техникч нар нь:

- Байгаль, цаг уурын хүнд, эрс тэс нөхцөлд
- Тэсэрч дэлбэрэх өндөр аюултай материалтай байнга харьцаж
- Шөнийн цагаар, нойр дутуу, биеийн болон сэтгэлзүйн ачаалал ихтэй
- Алслагдсан, эрсдэлтэй орчинд
- Эрүүл мэнд, амь насанд шууд аюул учруулах нөхцөлд ажиллаж байгаа нь хөдөлмөрийн хэвийн бус, хүнд нөхцөлийн бүх шалгуурыг хангаж байна.

Иймд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны **ерөнхий инженер, жолооч-техникч** нарыг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад оруулах нь зүйтэй гэж үзэж байна.





## 2. УСНЫ ХАРУУЛЫН АЖИГЛАГЧ

Байгууллагад хийгдсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, түүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжид (4.1–4.4) “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль болон MNS 5080:2023 стандартын шаардлагад нийцүүлэн ажлын байрны эрсдэлийг бууруулах, ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гэвч эдгээр зөвлөмж, арга хэмжээг усны харуул дээр ажилладаг **усны харуулын ажиглагчийн** ажлын байранд ус ихтэй, мөсөн бүрхүүлтэй зэрэг нөхцөлд хэрэгжүүлсэн байдал хангалтгүй, зарим тохиолдолд огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Ажилтны эрүүл мэндийн үзлэг, хяналт, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тандалт нь зөвхөн нэг хүн дээр хийгдсэн нь тухайн ажлын онцлогт нийцсэн түвшинд зохион байгуулагдаагүй;
- Жилийн турш тасралтгүй ажилтай холбоотой **ажлын цагийн зохицуулалт, илүү цагийн нөхөн олговор, амралтын нөхцөл** бүрэн шийдвэрлэгдээгүй;
- Гол үертэй, мөсний зузаан нимгэн үед ажиллахад амь нас эрсдэх нөхцлийг тодорхойлоогүй.

Иймд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр гарсан дүгнэлт, зөвлөмжүүд нь усны харуул дээр ажилладаг **усны харуулын ажиглагчийн** ажлын байрны бодит нөхцөлд **хэрэгжээгүй буюу хангалтгүй хэрэгжсэн** гэж дүгнэж байна.

**ДҮГНЭЛТ** Дээрх нөхцөл байдлаас үзэхэд тухайн ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангахгүй байгаа бөгөөд ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр хэвээр байна.

Иймд **усны харуулын ажиглагчийн** ажлын байрыг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамааруулан үзэх, мөн өмнө гарсан зөвлөмжүүдийг бодитоор хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## **ХӨДӨЛМӨРИЙН ХҮНД НӨХЦӨЛД ХАМААРУУЛАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ ҮНДЭСЛЭЛ ТАЙЛАН**

Усны харуулын үйл ажиллагаа нь жилийн турш цаг агаарын ямар ч нөхцөлд тасралтгүй хийгдэж байдаг гадаргын усны ажиглалт, хэмжилт судалгааг гаргаж гол мөрөн, нуурын усны горим, орчин зүйн тухайн үеийн байдлыг мэдээлэх, гол мөрөн нуурын усны мэдээг усан хангамж, усалтын систем, зам тээвэр, цахилгаан энерги, үйлдвэрлэл болон бусад зорилгоор ашиглах, зураг төсөл зохиоход шаардагдах усны горим, орчин зүйн лавлах, эмхтгэл гаргах, хаврын шар усны болон уруйн үер, мөсний зузааны мэдээ зэргээр ард иргэдэд мэдээлж ажилладаг өндөр ач холбогдолтой, онцлог чиг үүрэг бүхий үйл ажиллагаа юм.

Энэхүү үйл ажиллагаанд оролцож буй усны харуулын ажиглагч нь дараах онцгой нөхцөл, эрсдэл бүхий орчинд үүргээ гүйцэтгэж байна. Үүнд:

**1. Цаг уурын хүнд нөхцөлд ажиллах онцлог:** Усны харуулын ажиглагч нь жилийн дөрвөн улиралд, цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хэт халуун болон хэт хүйтэн зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлд тасралтгүй ажилладаг.

**2. Чийглэг, хүйтэн орчинд ажилладаг:**

Хавар, намар гол нуурын ус хүйтэн үед усан дотор ажилладаг. Өвлийн улиралд мөсөн дээр хүйтэн орчинд 3-5 цаг усны өнгөрөлт хэмжиж доороосоо даарч олон жилийн дараа нуруу, бөөрний өвчтэй болдог.

**3. Дуу чимээ болон физик нөлөөлөл:** Гол усны урсгалын дуу чимээ нь хүний сонсголын эрхтэнд сөргөөр нөлөөлөх боломжтой.

**4. Онцгой эрсдэлтэй шууд оролцоо:** Гол үертэй болон мөсний зузаан янз бүрийн нөхцөлд ажилладаг нь амь насанд шууд аюул учруулж болзошгүй өндөр эрсдэлтэй.

**ДҮГНЭЛТ** Дээр дурдсан нөхцөл байдлуудаас үзэхэд ус судлалын салбарын үйл ажиллагаанд ажиллаж буй усны харуулын ажиглагч нар нь:

- Байгаль, цаг уурын хүнд, эрс тэс нөхцөлд
- Чийглэг, хүйтэн орчинд
- Эрүүл мэнд, амь насанд шууд аюул учруулах нөхцөлд ажиллаж байгаа нь хөдөлмөрийн хэвийн бус, хүнд нөхцөлийн бүх шалгуурыг хангаж байна.

Иймд усны харуулын ажиглагчийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

**Усны горимын ажиглалт /Усны түвшин, агаарын температур, усны температур, салхи долгион, үзэгдэл, мөсний зузаан, хэвгий, тунадаст-ыг хийх**



*Зургийн тайлбар: Голын усны түвшний 08,20 цагийн хэмжилтийг гүйцэтгэж буй байдал*



*Зургийн тайлбар: Голын усны түвшний оройн 20 цагийн хэмжилт хийж буй байдал (хүйтний улиралд оройн 20 цагт үзэгдэх орчин харанхуй болж ажиглагчийн аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүсдэг)*


**Усны өнгөрөлт / усны гүн, голын өргөн, урсгалын хурд, талбай, өнгөрөлт / хэмжих, боловсруулах**



*Зургийн тайлбар: Дулааны улиралд усны өнгөрөлт хэмжиж буй байдал (нэг удаагийн өнгөрөлт хэмжилтэд 3-5 цагийг зарцуулдаг, ажиллах орчинд агаарын температур 20°C градусаас дээш байдаг)*



*Зургийн тайлбар: Өвлийн улиралд усны өнгөрөлт хэмжиж буй байдал (нэг удаагийн өнгөрөлт хэмжилтэд 3-5 цагийг зарцуулдаг, ажиллах орчинд усны температур 0-1 градус, агаарын температур -15°C градусаас доош байдаг)*



*Зургийн тайлбар: Өвлийн улиралд усны өнгөрөлт хэмжиж буй байдал (нэг удаагийн өнгөрөлт хэмжилтэд 3-5 цагийг зарцуулдаг, агаарын температур  $-15^{\circ}\text{C}$   $-30^{\circ}\text{C}$  градусуас доош байдаг)*

Хүйтний улиралд мөсний зузааны хэмжилтийг тогтсон өдрүүд буюу сар бүрийн 10, 20-ны өдрүүд болон сарын сүүлийн өдрүүдэд тэнцүү талт гурвалжны 3 оройд байрлахаар цэгүүдийг сонгон авч, 50 см-ээс багагүй диаметртэй байхаар цооног ухан мөсний зузаан, өвлийн өнгөрөлтийн хэмжилт хийдэг. Мөн голын нийт өргөний дагуу голын том жижгээс хамааран 2-4 м тутамд цооног гарган мөсний зузааныг хэмжинэ. Жижиг нуурын мөсний зузааныг нуурын эрэг орчим, төв хэсгийн хоёр цэгт, томоохон нуурын мөсний зузааныг эрэг орчим, эргээс 600-700 м зайд 3 км<sup>2</sup> талбайд тогтсон хугацаанд хэмжинэ.



*Зургийн тайлбар: Мөсний зузааны хэмжилт*


## ДУНДГОВЬ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил олгогчид зориулсан сургалтад хамрагдаж сертификат авсан.



2. 2024 онд Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумын цаг уурын өртөөнд тус бүр 30,0 сая төгрөгний засвар хийсэн. Ажиллах орчин сайжирч, таатай нөхцөл бүрдүүлсэн.





Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумын цаг уурын өртөө нэгдсэн халаалтын шугамд холбогдсон. Гурвансайхан цаг уурын өртөөг 2025 онд нэгдсэн халаалтад холбуулах 100 сая төгрөгний төсөв тавиулсан боловч 2 удаа зарлагдаад компани ороогүй, орсон компани шаардлага хангахгүй байсантай холбоотой буцааж татуулсан.

Мөн он дамжсан Мандалговь өртөө болон Сайхан-Овоо цаг уурын эко, байгальд ээлтэй барилга энэ жил ашиглалтанд орно.

2025 онд 6-н цаг уурын өртөөнд галын хор авч, байршуулсан.

Өртөөний албан хаагчдийн аюулгүй ажиллагааг хангаж, 6-н өртөөнд хөдөлгөөн мэдэрдэг камер суурилуулсан.



Энэ жил 8-н харуулд суулгах зорилт тавин ажиллаж байна.


2025 онд төвийн 26-н албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Улаанбаатар хотод яаралтай үзүүлэх шаардлагатай 7-н албан хаагчид цалинтай чөлөө олгосон. БОШЛ-ын эрхлэгч, инженер, техникчид сар бүр хор саармагжуулах сүүний мөнгө 50000 буюу жилд 1,8 сая төгрөг зарцуулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс 10 сая төгрөг шийдүүлж, лабораторид шинэ ширээ, цацраг хэмждэг багаж авсан. Лабораторийн ширээг Улаанбаатар хотоос авч ирж амжаагүй байна.

7 хоног бүр 2 цаг спорт зааланд төвийн албан хаагч нар тоглож, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлдэг.

Усны харуулын ажиглагч комбинзан 120,000, Гутал 50,000, мөсний өрөм 200,000 авсан нийт 370,000 болсон.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд маяк-д 645,0 төг, багаж хэрэгсэлд 1275,0 төг, Цазн 7 албан хаагчдыг Гамшиг ослын даатгалд хамруулсан 203,0 төг.



БОУАӨЯ-с мотоцикл шийдүүлж, Онги усны харуулд өгсөн.




Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд маяк-д 645,0 төг, багаж хэрэгсэлд 1275,0 төг, Цазн 7 албан хаагчдыг Гамшиг ослын даатгалд хамруулсан 203,0 төг.

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа технологи шинэчлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан тус төвөөс албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, холбогдох заалтыг тусгасан, 8 заалттай жилийн төлөвлөгөө баталж үүнээс хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 4 ажил төлөвлөн ажиллаж байна.

Үүнд: Дундговь аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олны уур амьсгалыг үнэлэх 2026 оны сэтгэл ханамжийн судалгааны зарим заалтыг доор тусгаж оруулав.


### 1.Хамт олны уур амьсгалыг үнэлнэ үү

53 responses



### 2.2025 онд дэвшүүлсэн "Хариуцлагатай төрийн албан хаагч" зорилтын хүрээнд зохион байгуулагдсан ажлуудыг үнэлнэ үү


53 responses



### 3.Таныг сэтгэл ханамжтай байхад чухал гэж үзсэн 3 зүйлийг сонгоно уу?

[Copy chart](#)

53 responses



### 4. Таны ажлын байранд тулгамдаж буй хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал?

- Ажлын хувцас - 8
- Өвлийн хувцас – 3
- Галалгааны асуудал - 10
- Ээлжинд гарах үед гэрэлтүүлэг муу
- Тог эрчим хүчний асуудал автоматын бүрэн гүйцэт ажиллагаа
- Ажлын байрны дулаан алдагдалтыг яаж шийдвэрлэх вэ?
- Шөнийн цагт гарахад харанхуй, урдаг ноход ойр байдаг.

- Гал түлж үнс асгаж хөө тортогтой ажилламааргүй бна . Галчаар их л ажиллаа
- Шатны гулгаа, гадна талын
- Хүйтэн л байна. Бусдаар ОК
- дулааныг сайн шийдвэрлэх
- пуужин хадгалах склад хэрэгтэй л байх юм.
- Ажиллах орчин нөхцөл
- Ajilin bagaj eruul mend


### Дүгнэлт

Судалгаанд нийт албан хаагчдын 54 нь буюу 91.5%-тай хамрагдлаа. Байгууллагын албан хаагчдын хамт олны уур амьсгалыг үнэлэх судалгаанд дүнд шинжилгээ хийхэд нийт судалгаанд оролцогчдын 96.3% нь хамт олны уур амьсгал, байгууллагаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдаг байна.

Мөн байгууллагыг хөгжүүлэх, албан хаагчдыг сэтгэл ханамжтай ажилаа гүйцэтгэхэд удирдлагын болон хамт олны харилцаа хандлага, зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг гэж 90-ээс дээш хувь нь хариулсан байна.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг батлан, хэрэгжүүлж ажиллаж байна.

2025 оны 05-р сард аймгийн төвийн ундны усны 4-н цэгээс шинжилгээ авч, лабораторийн шинжилгээний дүнг Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж аймгийн засаг даргад танилцуулан, ажилласан.

  
 ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
 ДУНДГОВЬ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
 ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 04 өдөр  
 Дугаар 0102  
 Мандалговь

Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн  
 зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:



1.Ажлын байрны Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Д.Цэнд-Аюуш  
 (ЦАЗН үйл ажиллагааны ерөнхий инженер)

Гишүүд: А.Батсайхан  
 (Холбоо сүлжээний инженер)  
 Н.Мөнхбат  
 (Урьдчилан мэдээлэхийн технологич инженер)  
 Б.Биханз  
 (Мандалговь өртөөний ахлах техникч)

Нарийн бичгийн дарга: Э.Буяндэлгэр  
 (Байгаль орчны шинжилгээний лабораторийн ерөнхий инженер)

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж төлөвлөгөө боловсруулан төлөвлөж ажиллахыг зөвлөлийн дарга (Д.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.АЗЖАРГАЛ  


2025 оны 05-р сард аймгийн төвийн ундны усны 4-н цэгээс шинжилгээ авч, лабораторийн шинжилгээний дүнг Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж аймгийн засаг даргад танилцуулан, ажилласан.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

С.Бунямагийн өргөн чөлөө 1-103, 7 дугаар баг,  
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090  
Утас/факс: (976) 7059 3894, Цэвэр шүүдэс em\_gazax@dundgov.gov.mn,  
Цахим хуудас: du.mohs.gov.mn

дсдс. 05.01 № 10-23-02/098-17

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА С.МӨНХЧУЛУУН ТАНАА

Шинжилгээний дүнгийн тухай

Танай байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лаборатори; Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн ундны усны нян судлалын болон химийн шинжилгээний үзүүлэлтийн дүнд эрүүл ахуйн дүгнэлт хийлээ.

№	Сорьцын нэр	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд																	
		Жинлэгдэх бодис	Пич мг/л	Кальцийн ион мг/л	Магнийн ион мг/л	Аммоний ион мг/л	Нийт төмөр мг/л	СХлорын ион мг/л	Сульфатын ион	Нитритийн ион	Нитратийн ион	Фосфатын ион	Фтор	Хагуулаг	Натри кали	ЕС µS/cm <sup>3</sup>	Гидрокарбонат	Эрдэсжилт	Орчин
	Хүлцэх агууламж мг/л			100	30	1.5	0.3	350	500	1.0	50	3.5	0.7-1.15	7				6.5-8.5	
1	Говийн ирээдүй сургууль /шүүлтүүр тэй/	илр	илр	илр	0.47	илр	0.06	5.4	5.8	илр	0.455	илр	0.14	0.04	11.3	45	13.4	36.3	6.60
2	Говийн ирээдүй сургууль /крант/	2.4	0.5	28.1	39.9	илр	0.08	83.7	199.7	илр	0.54	0.006	2.32	4.68	196.0	988	366.1	913.5	7.97
3	Цаг уурын нэгдсэн шугам	2.2	0.5	45.3	27.5	илр	илр	32.3	142.3	0.002	5.72	0.006	1.43	4.52	82.8	663	241.6	571.8	7.64
4	Мандалын 8-р гудамж 4-р худаг	2.6	0.5	37.5	36.1	илр	0.017	80.8	209.3	илр	0.55	0.008	2.39	4.84	195.0	944	366.1	924.8	7.93

№	Нянгийн шинжилгээний үзүүлэлтүүд	Шаардлага	Говийн ирээдүй сургууль /шүүлтүүртэй/	Говийн ирээдүй сургууль /крант/	Цаг уурын нэгдсэн шугам	Мандалын 8-р гудамж 4-р худал
	Сорьцийн нэр					
1	<i>Pseudomonas aeruginosa</i>	100/мл/-т илрэхгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
2	ББЕТ	1/мл/-т ≤100	37	35	17	12
3	<i>Salmonella spp</i>	25/мл/-т илрэхгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
4	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	100/мл/-т илрэхгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй

Сорилтын лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:**

Хими, нян судлалын шинжилгээгээр:

1. Шүүлтүүртэй ундны усанд илэрсэн химийн үзүүлэлтийн тоо нь шүүлтүүргүй ундны усны химийн үзүүлэлтүүдийн тооноос багассан, хатуулагийн хэмжээ 99.1 хувиар буурсан байна. Харин шүүлтүүртэй усанд илэрсэн бичил биетний ерөнхий тоо шүүлтүүргүй ундны усны бичил биетний ерөнхий тооноос 2-оор илүү байна.
2. Шинжлүүлсэн үзүүлэлтүүдийн хүрээнд дээрх ус нь Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ  Б.АНХБАЯР

----oOo----

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

## **1, Зохион байгуулалтын ажлын талаар:**

2025 оны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэж байна. БОШЛабораторид усны дээж авахад мөс цөмөрхөөс хамгаалж банз болон өөрийгөө уяха уяа зэргээр хангаж, зарим станцуудын болон төвийн хуучин камеруудыг засаж хэвийн ажиллагаатай болгосон.

БОШЛабораторийн ажилчдад хлад 5ш, резинэн бээлий, давхар шүүлтүүртэй маск, авто машины граш болон өртөөнүүдэд 7ш галын хор 280000 төгрөгийг бараа худалдан авахад зарцуулсан.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажил болон цаг уурын шинжилгээ судалгааны ажлыг доголдолгүй явуулах техникийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс цаг уурын 2 авто машинд засвар хийхэд 3,0 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэгийг худалдан авч засвар үйлчилгээ хийж аюулгүй байдлийг хангаж ажилсан.



Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийн бие бүрэлдэхүүнд тоног төхөөрөмж, техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг танилцуулж, аянга зайлуулагчтай болгож, алсын зайнаас утасгүй удирдлагаар пуужин харвах болон хээрийн ажиллагааны үед анхаарч ажиллах зүйлийн талаар тодорхой зааварчилгаа, зөвлөмж өгч ажилласны дээр үйл ажиллагаанд гарах тохиолдол бүрт хүн нэг бүрээр гарын үсэг зуруулан аюулгүй ажиллагааны дүрэм сахин ажиллахыг анхааруулж зөвлөмж өгч ажиллав.

Ус судлал аюулгүй ажиллагааны дүрмийг бүх харуулын ажиглагч нарт танилцуулан гарын үсэг зуруулж аюулгүй ажиллагааг хангах талаар зөвлөмж өгөн ажиллалаа.

Өртөө харуулуудад өвлийн улиралд цаг уурын ажиглалт хийхдээ төмөр шатнаас халтирч унахаас сэргийлж барих тулгуур бариул хийлгэх, лабораторийн химийн хортой бодисын хадгалалт, устгалтанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Мөн бүх өртөөнд хөдөлмөр хамгаалал галын булан байгуулж галын хороор хангаж аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

## **2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар:**

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журам, холбогдох хууль тогтоомжийг салбарын ажилтнуудад танилцуулж хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зохицуулалт, арга зүйгээр хангаж нийт ажилтан албан хаагчийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах, эрүүл

ахуйн ажиллагааны талаар шинэчилсэн заавар, журмуудыг хэвлэж салбар болгонд тарааж танилцуулж, гарын үсэг зуруулж ажиллав. Үүнд:

**Холбоо сүлжээний инженер, синоптик инженерүүдэд:**

- Холбоо, цахим тооцоолуурын тоног төхөөрөмж компьютер дээр ажиллах, сүлжээний шугам сүлжилт оруулгын төхөөрөмж дээр ажиллах галын аюулгүй байдлыг хангаж ажиллах зэрэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн.

**Усны ажиглагч инженер, техникч нарт:**

- Ус судлал, усны түвшний хэмжилт хийх, усны өнгөрөлт хэмжих, мөсөн дээр ажиллах, ус мөсөнд унасан хүнийг аврах, гүүр буюу дүүжин гарам дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа мөн гол мөрний усан дээр ажилладаг ажилчдад мөс цөмрөхөөс хамгаалсан банз, 400м урт уяа худалдан авахад 280,000 төгрөг, мөн усны техникч нартаа 11ш усны гутал 1,260,000 төгрөгийн бараа материал худалдан авч аюулгүй байдалыг ханган ажиллаж байна
- Мөн Шаамар сумын хэмжилт хийдэг гүүрний бэхэлгээ муу гагнаасаараа салсан байсныг сумын удирдлагуудад нь албан тоот хүргүүлэн хэвийн болгож гагнуулж янзлуулав.



**Байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер техникч нарт:**

- Байгаль орчны шинжилгээний лабораторид ажиллах, хүчил шүлттэй ажиллах, химийн хортой бодистой ажиллах, галын аюултай ба тэсрэмтгий бодистой ажиллах, лабораторын цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дээр ажиллах, хийн баллонтой ажиллах, химийн сав суулгатай ажиллах, химийн хортой бодис урвалжийг хадгалах, Лабораторын ажилтныг шинжилгээний ажил хийж байх үедээ анхаарал болгоомжтой ажиллах, хөнгөн шарх авсан

тохиолдолд анхны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх үүднээс ослын үед анхны тусламж үзүүлэх ерөнхий журмыг уншуулж танилцуулсан.

### **Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бие бүрэлдэхүүнд:**

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг зохион байгуулахдаа ЦУОШГ, ИНЕГ-ын даргын 2011 оны хамтарсан А/450/167 дугаар тушаалаар батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах” журам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны хамтарсан А/32/231 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн холбогдох заалт болон 2010 оны ЦУОШГазрын даргын 66 дугаар тушаал хүчингүй болж 2017 оны ЦУОШГазрын даргын А/ 38 дугаар тушаалаар шинэчлэгдсэн цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллаа. Үүнд:

- Цаг агаарт зориудаар нөлөөлөх аюулгүй ажиллагааны заавар, газрын төхөөрөмж дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, пуужин галт хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хадгалах, харвах төхөөрөмж дээр ажиллах, газрын генератор дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, явуулын радарын станцын аюулгүй ажиллагаа зэрэг заавруудыг танилцуулж үйл ажиллагаа явуулах бүрт хүн тус бүрээр тогтмол гарын үсэг зуруулж ажиллав.3 экспедицэд 10ш ажлын хувцас, лаборторын ажилчидад 5ш хлад,үйлчилэгчид 1ш хлад авахад 1,600,000 төгрөг зарцуулж ажилласан.
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бүрэлдэхүүнд ажиллах 4 хүнийг сургалтанд хамруулан шалгалтыг нь өгүүлж тэнцсэн хүмүүсээ мэргэшүүлж үнэмлэхтэй болгосон.



### **Уур амьсгалын инженер техникч, ХАА-н инженер техникч, Цаг уурын станц харуулын ажиглагч нарт:**



Галын аюулгүй байдал, Цахилгааны аюулгүй байдал, Цаг уурын өртөөн дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагааны заавар, компьютер, цахим тооцоолуур дээр ажиллах мөн хальтрахаас болгоомжилсон сануулга, Салбар ахалсан инженерүүдээр нь болон өөрийн биеэр шалган туслах ажлын үед газар дээр нь очиж зааварчилгаа өгч, ажиллаж байсан.

### **3. Бусад ажлын талаар**

Бүх станцуудад гал гарч болох шалтгаан нөхцөлүүд, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, гал гарсан үед авах анхан шатны арга хэмжээ, галын дуудлага өгөх, гал унтраах хэрэгслийг хэрэглэх, ашиглах, хүн эд материал аврах гэх мэт заавар зөвөлгөөг өгч, элс хийх хувин, эмийн сан, галын хор зэргээр хангаж галын булантай болгосон.

- Ажилчдыг хачигны эсрэг вакцинд хамруулсан

- Албан хаагчдыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг шинжилгээнд хамаруулсан.
  - Өвлийн улиралд хальтиргаа гулгаанаас сэргийлж үүд хавийн болон хуваарьт газрынхаа цасыг, цас орсны дараагаар нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж цэвэрлэж хэвшсэн .

----oOo----

## **ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ (ЦАЗН) ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ**

Төв аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарт зориудаар нөлөөлөх (ЦАЗН) үйл ажиллагааг 2008 оноос эхлэн тасралтгүй явуулж байна. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг үе шаттайгаар сайжруулан ажиллаж байна.

### **Хөдөлмөрийн нөхцөлийн онцлог**

Төв аймаг нь газар нутгийн хувьд 27 сумтай Газар тариалан, мал аж ахуй үйлдвэрлэл зонхилсон онцлогтой ба ЦАЗН үйл ажиллагаа явуулахад цаг хугацаа их шаарддаг, уулархаг өндөр газарт цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хүйтэн зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлд гадаа орчинд ажилладаг. Мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн оройн 20:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд явагддаг тул шөнийн ээлжинд ажиллах, нойр дутуу, биеийн ачаалал ихтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага үүсдэг.

### **Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

ЦАЗН үйл ажиллагаанд оролцогч албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, ажлын нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн байна.

1. Зуунмод Бороо - 1,Зуунмод бороо-2 оролцогч албан үйл ажиллагаа явуулах нөхцлийг сайжруулан хээрийн гаралтын үед хэрэглэх борооны цув ОП цув / 6 ш / , духны гэрэл /6ш/ -ээр хангаж ажиллалаа





2. 2024 оноос эхлэн экспедицийн бүрэлдэхүүнийг /4 албан хаагч/ гэнэтийн ослын даатгалд хамруулж, ажилтнуудын нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.

3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зааврын зургаадугаар бүлгийн 11 дэх заалтад заасны дагуу борооны пуужин, сум тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг бүрэн хангаж Л-200 автомашиныг аюултай ачаа тээвэрлэх тэмдэг тэмдэгтээр бүрэн тоноглолоо.

4. 2024 оноос эхлэн экспедицийн бүрэлдэхүүнийг гэнэтийн ослын даатгалд хамруулж, ажилтнуудын нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.

5. ЦАЗН үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд Пургон, Л-200 автомашины ээлжит засвар үйлчилгээний зардлыг жил бүрийн тогтмол Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдүүлж 2020-2026 онд нийт 7,2 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж ажилтнуудын ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.

6. Экспидийн бүрэлдэхүүн үйл ажиллагаа явуулахын өмнө учирч болзошгүй эрсдлээс сэргийлж аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцаж гарын үсгээ зурж ажилладаг.



### ГОЛЫН УСНЫ ГОРИМЫН АЖИГЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙХ ҮЕИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ, ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

Төв аймгийн УЦУОШТ–н хэмжээнд 6 ус судлалын харуул үйл ажиллагаа явуулж байна. Ус судлалын салбар нь голын үертэй болон цас, бороо, шуурга, хүчтэй салхи, хүйтэн зэрэг байгалын аюултай үзэгдлийн үед, хавар, намрын мөсний үзэгдэлтэй үед, өвөл мөсөн дээр ажиллаж биеийн ачаалал ихтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага үүсдэг.

Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

1. УЦУОШТ-н ус судлалын инженер, харуулын ажиглагч нарын 7 албан хаагчдыг 2022 оноос эхлэн "МИГ ДААТГАЛ"- ХХК "Гэнэтийн ослын даатгалд"-д хамруулсан



2. Ус судлалын харуулын ажиглагч нард 2022 оноос эхлэн жил бүр 12-3 саруудад 3 ээлжийн хөвөнтэй бээлийгээр хангаж ажиллалаа. 2022-2026 онд 862000 төгрөг
3. Туул-Алтанбулаг харуул нь 3-6 саруудад ус бага бохирдол ихтэй учир тухайн саруудад харуулын ажиглагчийг бохирдлоос сэргийлж резинэн бээлийгээр хангаж ажилладаг.



4. 2012 оноос эхлэн ус судлалын харуулын ажиглагч нарыг учирч болзошгүй эрсдлээс сэргийлж ажиглалт, хэмжилт хийх өмнө аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцаж гарын үсгээ зурж хэвшээд байна.
5. Харуулын 6 ажиглагч нарт ажиглалт, хэмжилт хийхэд шаардагдах Аврах хантааз, усны гутал, ажлын бээлий зэргээр ханган ажиллаж байна.



1. ТӨВ БОЛОН ОРОН НУТГИЙН ЦУУАСАЛБАРЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:


- Мөн төвийн байр, архивын өрөө болон 11 цаг уурын станцын барилгын ослын үеийн схем галын хорыг бүрэн шинэчилж ажиллаа.



- 2025 онд Төв болон орон нутгийн 65 албан хаагчид хөдөлмөр хамгааллын цамцыг 5,817,500 төгрөгөөр хангаж ажиллалаа.



- 2024 онд өртөө, харуулын ажиглагч, БОШЛ-н, ус судлалын харуулын ажлын байрны хөдөлгөөнийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг –“Арш хур”ХХК -аар хийлгэсэн.



--000--